“ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР

2024

АГУУЛГА

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ 5
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ 6
1.1. Асуудлыг тодорхойлох (Салбарын мэргэжилтнүүдтэй уулзах, статистик мэдээлэл судлах, өмнө нь хийгдсэн судалгааны материалыг судлах зэргээр асуудлыг тодорхойлно) 6
1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох 8
1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөлийг тодорхойлох 10
1.4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нөхцөл байдлыг тандах 11
1.5. Хуулийн хэрэгжилтийн явцад үүсээд байгаа хүндрэл, бэрхшээл, хийдлийг судлах 12
1.6. Олон улсын шинэ чиг хандлага, зөвлөмж, бусад улсын туршлага, загвар хууль зэргийг судалж холбогдох мэдээллийг цуглуулж, анализ хийх 12
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ 16
ГУРАВ. ТУХАЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТӨЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ 16
3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах 17
3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх 18
3.3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх 18
3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх 18
3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх 18
3.6. Захиргааны шийдвэр гаргах 19
3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах 19
ДӨРӨВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ 19
4.1. Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо 19
4.2. Эвлэрүүлэн зуучлалын төвийн зохион байгуулалт 24
4.3. Эвлэрүүлэн зуучлалын загварууд буюу эвлэрүүлэн зуучлалыг дэмжих арга механизмууд 27
4.4. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах арга замууд 31
4.5. Эвлэрүүлэн зуучлагчид тавих шаардлага 39
4.6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх маргааны төрөл хүрээг өргөжүүлэх эсэх 42
4.7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа 44
4.8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж 45

4.9. Эвлэрлийн гэрээнд зайлшгүй тусгах ёстой зүйлс 47
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 48
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 55
ХАВСРАЛТ №1 МЭРГЭЖИЛТЭНТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА 57

Судалгааны захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааны ажлыг санхүүжүүлэгч: Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)

Судалгааны багийн гишүүд:

Багийн ахлагч - Г.Цагаанбаяр /Хуульч, судлаач/
Багийн гишүүн - О.Буян-Ундрах /Эрх зүйч, судлаач/

“ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Энэхүү Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн[1] 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтад “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах, тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох, зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тохиодолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгааг хийх” гэж заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчлэсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын [2] 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал" /цаашид “аргачлал" гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийх

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох

Гурав. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах

Дөрөв. Хуулийн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа, бодлогын хувилбарууд, харьцуулсан дүгнэлт

Тав. Дүгнэлт, зөвлөмж

---

[1] Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

[2] Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Аливаа хэрэг маргааны шинж чанар болон талуудын нөхцөл байдлаас шалтгаалан түүнд тохирсон маргаан шийдвэрлэх олон төрлийн арга, механизмыг бий болгох нийгмийн хэрэгцээ шаардлага өнөөг хүртэл байсаар байна. Шүүхийн бус аргаар хэрэг маргааныг шийдвэрлэх тогтолцоог бий болгохын давуу тал нь маргагч талууд өөрсдийн хүсэл зоригийн үндсэнд асуудлыг шийдвэрлэхэд орших ба ингэхдээ хувь хүний нууц болон бизнесийн үйл ажиллагааны нууцлалыг хадгалах, хялбар бөгөөд түргэн шуурхай байдлаар маргаанаа шийдвэрлэх, олон талын мэргэжилтний мэдлэг, ур чадварыг ашиглан нарийвчилсан шийдлийг эрэлхийлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Үүний үр дүнд тухайн бодит нөхцөл байдалд илүү ойртсон талуудад харилцан ашигтай шийдлийг бий болгох боломжтой юм.

Монгол Улсад шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх эрх зүйн тогтолцоо одоог хүртэл хөгжсөөр байгаа бөгөөд уг хөгжлийн түвшнийг дараагийн шатанд гаргахын тулд одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох, хэрэгцээ шаардлагыг тандан судлах, үүсээд буй асуудалд дүн шинжилгээ хийх, цаашид тодорхой хариу арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх нь зүйтэй билээ.

Хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, асуудалд дүн шинжилгээ хийх үе шат нь дараах зүйлсийг тодорхойлно. Үүнд:

1.1. Асуудлыг тодорхойлох (Салбарын мэргэжилтнүүдтэй уулзах, статистик мэдээлэл судлах, өмнө нь хийгдсэн судалгааны материалыг судлах зэргээр асуудлыг тодорхойлно)

Монгол Улсад анх 2012 онд шүүхийн шинэчлэлийн багц хуулийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, эрх зүйн маргааныг шийдвэрлэх сонголтот хувилбарыг хөгжүүлэх зорилгоор эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг баталсан.[3] Тус хуулиар эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоох, эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн маргаан, гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр хуулийн үйлчлэлийн хүрээг тогтоожээ. Ийнхүү Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын тухай тусгайлсан хууль хэрэгжиж эхэлсэнээр иргэд үүссэн маргааныг шүүхэд хянан шийдвэрлүүлэхтэй харьцуулахад хөрөнгө мөнгө, цаг хугацааны хувьд хэмнэлттэй, өөрт ашигтай байдлаар шүүхийн бус аргаар хянан шийдвэрлүүлэх таатай нөхцлийг бүрдүүлсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд үр дагаварын үнэлгээ хийх шаардлагатай байдаг. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2013 оны 4 сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 11 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд хуулийн хэрэгжилтийн үр дагавар, нөхцөл байдал болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилготой судалгаа шинжилгээний ажлууд хийгдсэн.

Үүнээс дурьдвал Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ нь 2015 болон 2020 онуудад хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Уг судалгаагаар “...өнөөг хүртэл энэ хууль амжилттай хэрэгжиж ирсэн...” гэх судалгааны ерөнхий дүгнэлт гарчээ. Тодруулбал

[3] М.Батчимэг “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, түүний орчин үеийн чиг хандлага”, УБ 2018 он., 7 дахь тал.

Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоог хуульчилсан бөгөөд 2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн гол цөм нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн байна хэмээн дүгнэжээ. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны статистик тоон мэдээллээс үзвэл 2014 оноос 2020 оныг хүртэлх 6 жилийн хугацаанд нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн бөгөөд энэ нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг тэр хувиар багасгаж буй ач холбогдолтой юм.[4]

Харин шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа бөгөөд үүний учир нь төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод эвлэрүүлэн зуучлагч ажиллаж, талуудын маргааныг амжилттай шийдвэрлэсэн ч тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаггүй нь тухайн маргаанаар дахин шүүхэд хандах нэмэлт зардал үүсэх, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж байсантай холбоотой гэжээ.[5] Үүнээс үзвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт зохих түвшинд хүрч чадаагүй байна.

Мөн 2020 оны 5 сард ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар (цаашид “АИХЭГ” гэх)-аас Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ийн санал, дүгнэлт”-ийг боловсруулсан бөгөөд тус баримт бичигт “Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30.1-д зааснаас үзвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь заавал шүүхээс санал болгохгүйгээр хийгдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хамаарч буй эсэхийг тодруулах шаардлагатай байна. Монгол Улсад эвлэрүүлэн зуучлал хийх боломжийг нэмэгдүүлэхийн тулд хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хамруулах нь зүйтэй” гэх саналыг мөн тусгасан байдаг.[6] Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжих талаар хуульд нарийвчлан тусгагдаагүй болохыг онцолж байжээ.

Түүнчлэн 2023 оны 12 дугаар сард хийгдсэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны тайлангийн дүгнэлт хэсэгт манай улс 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг батлахдаа Олон Улсын Арилжааны Эвлэрүүлэн Зуучлал болон Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хийгдсэн олон улсын эвлэрлийн гэрээний тухай загвар хуулиас[7] жишээ аван хуулийн төслийг бэлтгэсэн талаар дурьдсан. Уг загвар хуулийн 14 дүгээр зүйлд хэрвээ талууд маргаанаа шийдвэрлэн эвлэрлийн гэрээ байгуулсан нөхцөлд тус эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй байж болно хэмээн заасан бөгөөд манай орны зүгээс төсөл бэлтгэхдээ уг зохицуулалтыг оруулалгүй орхигдуулсан нь өнөөгийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллагуудын дэргэдэх эвлэрүүлэн

---

[4] Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тойм”, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2020 он., 128 дахь тал.

[5] ЛСА, Шүүхийн ерөнхий зөвлөл “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”, УБ 2020 он., 84 дэх тал.

[6] ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ийн санал, дүгнэлт” (Саналын дугаар: JUD-MNG/362/2019), 2020.05.11., 13 дахь тал.

[7] НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн комиссын цахим хуудас (Сүүлд үзсэн: 2024.02.26) https://shorturl.at/mnrR7

зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсоны гол шалтгаан нөхцөл болж буй[8] талаар судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

Эндээс дүгнэхэд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлж болохоор заасан хэдий ч энэ заалтын хэрэгжилт практикт бодитоор биелэгдээгүй нөхцөл байдлыг дээрх судалгаануудын үр дүнгээс харж болохоор байна. Дээр дурьдсанчлан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон шалтгаан нь эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулан байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг шүүхийн шийдвэрийн нэгэн адил авч үзэхгүй байгаатай холбоотой бөгөөд энэ нь өнөөгийн Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын тогтолцоонд тулгамдаж буй асуудал болоод байна.

Тиймээс хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвийн эрх зүйн байдлыг тогтоох, цаашлаад тус төвөөр дамжуулан байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийн баталгаажуулах механизмыг бүрдүүлэх талаас нь олон улсын сайн туршлага, тэдгээрийн санал дүгнэлтэд үндэслэн тохиромжит шийдлийг олох хэрэгцээ шаардлага үүссэн. Үүнд дараах асуудлуудыг нарийвчлан тодорхойлж бодлогын шийдлийг дэвшүүлэх замаар хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагатай эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Монгол Улсад 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсанаас хойш тус хуулийн 8 дугаар зүйлд заасан шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах хэд хэдэн албан ёсны эрх бүхий, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалттай эвлэрүүлэн зуучлах төвүүд нээгдсэн. Эдгээрээс дурьдвал Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнесийн Маргааныг Эвлэрүүлэн Зуучлах Төв анх 2014 онд байгуулагдсан бөгөөд байгуулагдсан үеэсээ нийтэд хүрч үйл ажиллагаагаа амжилттай явуулж байсан.[9] Гэвч тус төвөөс баталсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийн асуудлаас шалтгаалан төвөөс шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бизнесийн маргаантай талуудад санал болгож байсан ба үүнийгээ дагаад иргэд, олон нийт тус төвд хандан үйлчилгээ авахаа больсон байна. Улмаар 2015 оноос хойш тус төв нь өргөдөл хүлээн аваагүй байна.

Шүүхээс гадуурх буюу төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төвөөс явуулсан эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны үр дүнд талуудын байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг албадан гүйцэтгэх боломжгүй байгаа бөгөөд энэ нь маргаанаа түргэн шуурхай, хямд төсөр аргаар шийдвэрлүүлэх хүсэлтэй байгаа нийгмийн бүлгийн эрх ашигтай холбогдоно.

Өөрөөр хэлбэл хэдий эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар маргаанаа шийдвэрлүүлж, талууд эвлэрлийн гэрээ байгуулсан ч гэрээний гүйцэтгэл хангагдахгүй байх нөхцөл бүрдсэнээр дахин шүүхэд хандах шаардлагатай болж буй юм. Бодит байдал дээр төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн хороодын дэргэд байгуулагдсан

---

[8] М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он., 25 дахь тал.

[9] Мөн тэнд., 10 дахь тал.

эвлэрүүлэн зуучлах төв нь өөрөө шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг санал болгож байснаас үзэхэд тус төвөөс үйлчилгээ авсан иргэд гэрээний гүйцэтгэлээ хангагдахгүй байгаа талаар уламжилж, энэ нь тал талдаа төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж байжээ. Эндээс үзэхэд дээрх асуудлын үндсэнд ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд нь шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвүүдэд хандан маргаанаа хянан шийдвэрлүүлэх хүсэл сонирхолтой иргэн, хуулийн этгээд, түүнчлэн тус төвүүдээс үр ашиггүй үйлчилгээ авсан хүмүүс гэж тодорхойлж болохоор байна.

Түүнчлэн, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан шүүн таслах ажиллагааны дүн мэдээнээс үзвэл Монгол Улсад жилд 45 орчим мянган иргэний хэрэг маргааныг шийдвэрлэдэг байх бөгөөд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал шүүхийн ачааллыг 20-25 орчим хувиар бууруулдаг болох нь статистакаас харагдаж байна. (Хүснэгт 1 үзнэ үү). Энэ нь нөгөө талаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ач холбогдлыг иргэн, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын зүгээс маргаанаа түргэн шуурхай шийдвэрлүүлэх нэг боломж гэж ойлгож, үйлчлүүлж байгааг харуулах бөгөөд нийгэмд шүүхийн бус аргаар маргаанаа түргэн, шуурхай, зардал багатай шийдвэрлүүлэх эрэлт хэрэгцээтэй байгааг ч нотлон харуулна.

Гэхдээ, шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тоо нэмэгдэж ачаалал ихсэх нь нөгөө талдаа эвлэрүүлэн зуучлагч нарын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, ажлын ачаалал ихэссэнээр өргөдлийг буцаах, эвлэрүүлэн зуучлагч нарын орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсэх зэрэг сөрөг үр дагавар ч үүсч байна. Тухайлбал, Баянзүрх дүүргийн ИХАШШ- дэх эвлэрүүлэн зуучлагч “Ачаалал ихтэй дүүргийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлал дээр гэр бүлийн маргааныг хүлээн авч шийдвэрлэдэг эвлэрүүлэн зуучлагч эсвэл сэтгэл зүйчийн орон тоо нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2021 онд нэг эвлэрүүлэн зуучлагчид ногдох өргөдлийн тоо 1324 байгаа нь ажлын ачаалал ихсэж, 1 өргөдлийг шийдвэрлэх хугацаа багассанаар өргөдөл шийдвэрлэлтийн чанар буурах магадлалтай байна” гэжээ.

Хүснэгт 1 . Шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэсэн өргөдлийн тоо

Он	ЭЗА-д гаргасан нийт өргөдөл, нэхэмжлэл	Эвлэрлийн гэрээ байгуулсан	Нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо	Шүүхийн ачааллыг бууруулсан хувь
2014 он	6427	2847	33996	8,4
2015 он	15437	7881	32181	22,2
2016 он	15716	8908	35493	22,4
2017 он	16952	10013	39773	25,5
2018 он	16029	8711	41363	21,1
2019 он	17717	9227	37387	24,7
2020 он	22078	10415	46389	22,5

2021 он	19742	8480	38370	22,1
2022 он	22059	9373	45895	20,4

2022 онд Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 81.6 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 435.1 хэрэг ногдож байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал шүүгчийн тоо 82.9 байснаас 81.6 болж 1.3 хүнээр өсөж, нэг шүүгчид ногдох хэргийн тоо 322.6 байснаас 435.1 хэрэг болж 112.5 хэргээр өссөн дүнтэй гарсан байна[10]. Зүй нь иргэний хэргийн анхан шатны 1 шүүгч жилд 200 хэрэг шийдвэрлэдэг байх нь ажлын ачаалал хэвийн гэж үзэх стандарт байдаг[11]. Гэтэл иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал 100-аас дээш хувь давсан байгаа нь иргэний шүүхийн ажлын ачаалал хэт их, 2 шүүгчийн ажлын ачааллыг 1 шүүгч авч ажиллаж байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, шүүх хурал хойшлох зэргээр сөрөг үр дагаврыг дагуулах, улмаар талуудад зардал мөнгөний болоод цаг хугацааны ихээхэн алдагдал бий болгох нь дамжиггүй. Шүүхийн ажлын ачаалал ийм өндөр байгаа нь нийгэмд шүүхийн бус замаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрэлт хэрэгцээ өндөр байгааг, хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжих орон зай байсаар байгааг мөн харуулж байна.

Иймд, шүүхийн бус хувийн эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг хөгжүүлэх нь иргэн аж ахуйн нэгжийн хэрэг маргаанаа хурдан шуурхай, зардал багатайгаар шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх, хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх нэг сонголтот хувилбарыг бий болгох үүднээс нийт иргэд, аж ахуйн нэгжид хамаарах ба тэдний эрх ашгийг хөндөх гэхээс илүүтэйгээр, эрхээ хамгаалах нэг механизмыг бий болгох замаар иргэний эрхийг хангах зорилготой байна.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөлийг тодорхойлох

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд үйл ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлал буюу шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон шалтгаан нь эвлэрүүлэн зуучлалын гэрээг баталгаажуулдаггүй, улмаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боломжгүй байсантай холбоотой байна. Мөн, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалтай харьцуулахад зардал мөнгөний хувьд өндөр зэрэг шалтгаан нөхцөлтэй.

Тухайлбал МҮХАЖТ-н дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв нь үүсгэн байгуулагдсан эхний жил буюу 2014 онд 24 хэрэг маргаан, 2015 онд 10 хэрэг маргаан, 2016 онд 2 маргаан, 2017 оны 1 сараас 4 сар хүртэл 2 маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсан байна. [12] Ийнхүү жил ирэх тусам тус төв хандан шийдвэрлүүлэх хэргийн тоо буурсан нь талуудын хооронд байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл буюу биелэлт байхгүйгээс эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар

[10] Монгол улсын шүүхийн 2022 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. https://www.judcouncil.mn/site/news_full/12877

[11] “Хөгжлийн санаачилга” ТББ-ийн 2018 онд ШЕЗ-ийн захиалгаар анхан шатны шүүхийн шүүгчийн ажлын ачаалал тооцох судалгаа.

[12] Э.Санчир-Уяа “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлалд тулгамдаж буй асуудал”, УБ 2017 он., 4, 5 дахь тал.

маргаанаа хянан шийдвэрлүүлсэн талууд дахин шүүхэд хандаж хөрөнгө мөнгө, цаг хугацаа алдах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байсан.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулагдсан эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын баталсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хэрхэн хангах, эвлэрлийн гэрээг баталгаажуулах механизмыг бүрдүүлэх, цаашлаад шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалыг үр дүнтэй хэрэгжих нөхцлийг бий болгох замаар өнөөгийн Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын цогц тогтолцоог бэхжүүлэх нь зүйтэй байна.

1.4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нөхцөл байдлыг тандах

Монгол Улсын нөхцөлд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх судлагдсан байдлаас үзвэл 2015 болон 2020 онуудад Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар үр нөлөөний судалгааны ажлууд хийгдсэн бөгөөд тэдгээрийн дүгнэлтэд хуулийн хэрэгжилт сайн буюу эерэг үр дүнтэй байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 болон 8 дугаар зүйлд заасанчлан Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа шүүхийн дэргэд болон шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдэд хэрэгжих байдлаар заасан боловч зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хэрэгжилт сайн гэсэн үр дүнг судалгааны дүгнэлтээс харж болно.

Гэвч бодит байдал дээр зөвхөн шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлал л үр дүнтэй хэрэгжиж байгаа буюу шүүхээс гадуурх байгууллагад эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдахгүй байгаа болох нь 2023 оны “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны[13] тайлангаас харж болох юм. Тус тайланд бизнес эрхлэгчид шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандах болсон давуу тал нь эвлэрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах боломжит эрх зүй орчин бүрдсэнтэй холбоотой талаар дурьджээ. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн дүрэмд гэрээний гүйцэтгэлтэй холбоотой уг асуудлыг шийдвэрлэж болохоор ямарваа нэгэн зохицуулалт байхгүй байна гэжээ.[14]

Эндээс үзвэл хуульд заасан эвлэрүүлэн зуучлалын хоёр механизмыг хамтад нь хөгжүүлж, үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг аль ч шатанд шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх байдлаар зохицуулалт хийх шаардлагатай байна. Судалгааны явцад эвлэрүүлэн зуучлалын мэргэжилтэнтэй Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар ярилцлага хийсэн бөгөөд ярилцлагаас дурьдвал

> *Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас…*
>
> *Сүүлийн үеийн дэлхий нийтийн чиг хандлага нь маргаж буй талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэчихсэн тохиолдолд үүнийг заавал дахин баталгаажуулах шаардлагагүй. Бизнес эрхлэгчид өөрсдийн засаглалаараа хоорондоо үүссэн*

[13] М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он.

[14] Мөн тэнд., 11 дэх тал.

маргааныг шийдвэрлэсэн байхад шүүх заавал үүнийг баталгаажуулж оролцох шаардлагагүй буюу тэр эрхэнд нь хөндлөнгөөс оролцох шаардлагагүй гэж үзэж байгаа.

НҮБ-аас 2018 онд баталсан “Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлал болон эвлэрлийн гэрээний загвар хууль”-ийн 14 дүгээр зүйлд хэрвээ талууд маргаанаа шийдвэрлэн эвлэрлийн гэрээ байгуулсан нөхцөлд тус эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй байж болно хэмээн заасан байдаг. Эндээс үзэхэд арилжааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмаар батлагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулахтай холбоотой асуудал үүсээд байгаа бөгөөд үүнийгээ дагаад эвлэрлийн гэрээг баталгаажуулах ямар хувилбар манай улсад илүү тохиромжтой талаас нь үнэлэлт хийх шаардлагатай.

1.5. Хуулийн хэрэгжилтийн явцад үүсээд байгаа хүндрэл, бэрхшээл, хийдлийг судлах

Үндсэндээ 2012 онд батлагдсан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 болон 8 дугаар зүйлд заасны дагуу эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эсхүл төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагч эрхлэхээр заасан. Тус хуулийн 27 дугаар зүйлд эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах тухай зохицуулсан бөгөөд 27.2 дахь хэсэгт *“Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана*” гэж заажээ. Харин 27.1 дэх хэсэгт *“Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй”* хэмээн заасан байна. Эндээс харахад Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн баталсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хэрхэн хангагдах нөхцлийг бүрдүүлээгүй буюу дахин шүүхэд хандах эрхтэй гэх байдлаар зохицуулсан нь хүндрэл бэрхшээлийг үүсгээд байна.

Угтаа хуульд шүүхийн болон шүүхээс гадуурх гэх хоёр тусдаа бүтцэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах байдлаар зохицуулсан боловч зөвхөн шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны биелэлтийг хангасан байгаа нь энэ хууль хангалттай бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа гэж дүгнэхэд учир дутагдалтай байна.

1.6. Олон улсын шинэ чиг хандлага, зөвлөмж, бусад улсын туршлага, загвар хууль зэргийг судалж холбогдох мэдээллийг цуглуулж, анализ хийх

НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL)-оос анх 2002 онд “Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлалын загвар хууль”-ийг баталсан. Үүнээс хойш 2018 онд тус загвар хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “Олон улсын арилжааны эвлэрүүлэн зуучлал болон эвлэрлийн гэрээний загвар хууль” нэртэйгээр дахин баталжээ.[15] Иймхүү дахин батлахдаа эвлэрлийн гэрээ болон түүний хэрэгжилттэй холбогдох тусгайлсан бүлгийг оруулан зохицуулж өгсөн байна.

[15] НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн комиссын цахим хуудас (Сүүлд үзсэн: 2024.02.26) https://shorturl.at/mnrR7

Жилээс жилд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтэй этгээдүүдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь эвлэрүүлэн зуучлал шүүхийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс илүү хялбар процедураар явагддагтай холбоотой. Бусад улс оронд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь тухайн орны онцлогоос хамааран ялгаатай байх боловч нийтлэг чиг хандлага нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуурх хувийн секторт байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааг хамтад нь зэрэгцүүлэн хөгжүүлж байна. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сонгох боломжийг өргөн хүрээнд бүрдүүлж, эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг үр дүнтэй явуулах зорилгод чиглэгдэж байна.

Тухайлбал, 2008 оны 5-р сарын 21-ний өдөр Европын парламентаас иргэний болон арилжааны маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарим асуудлын тухай дугаар 2008/52/EC зааварчилгааг баталсан[16] бөгөөд уг зааварчилгааны хүрээнд хийгдсэн нарийвчилсан дүн шинжилгээний эмхэтгэлд эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг тооцох аргачлалын талаар дэлгэрэнгүй авч үзжээ. [17] Тус аргачлалыг тайлбарлах замаар өнөөгийн Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөтэй байдлыг тооцож үзье.

Зураг.1 Эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөтэй байдлын матриц



Энэхүү аргачлалын хүрээнд Balanced Relationship Index буюу тэнцвэрт хамаарлын индекс, Success Mediation Index буюу амжилттай эвлэрүүлэн зуучлалын индекс гэх үндсэн хоёр хэмжүүрээр үр нөлөөг тооцдог. Хэмжүүр тус бүр 50 хувиас дээш байх тохиолдолд II хэсэг болох эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тоо зохих хэмжээнд байгаа бөгөөд тэдгээрийн талаас илүү хувь нь амжилттай явагддаг гэх ангилалд хамаарна. Энэ нь тухайн бүс нутагт эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны хэрэгжилт өндөр, үр нөлөөтэй байгааг илтгэдэг.

[16] Directive 2008/52/EC of the European Parliament and of the Council of 21 May 2008 on certain aspects of mediation in civil and commercial matters https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2008:136:0003:0008:En:PDF

[17] Policy Department for Citizens' Rights and Constitutional Affairs. (2016). "The Implementation of Mediation Directive:Compilation of In-depth Analyses" https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2016/571395/IPOL_IDA%282016%29571395_EN.pdf

A. Тэнцвэрт хамаарлын индексийг дараах томьёоны дагуу тооцно.

$$\text{Balanced Relationship Index} = \frac{\text{Number of mediations}}{\text{Number of judical proceeding}} \times 100$$

Эвлэрүүлэн зуучлал болон шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо тэнцвэртэй байх нь шүүхийн ачааллыг бууруулах арга хэлбэр болдог. Тодруулбал 1-ийг харьцах нь 1 буюу хянан шийдвэрлэгдэж буй 2 маргаан тутмын 1-д нь эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагддаг бол дээрх харьцааг тэнцвэртэй гэж үздэг байна. Эвлэрэх боломжтой маргааныг заавал шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагагүй буюу өөрөөр хэлбэл шүүх өөрөө хязгаарлагдмал нөөц бүхий бүтэцтэй учраас шүүхээр л шийдвэрлэгдвэл зохих хэрэг маргаануудад уг нөөцийг ашиглах боломжийг өгөх ёстой. Ингээд үзвэл эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан шүүхийн ачааллыг бууруулах боломжтой юм.

B. Амжилттай эвлэрүүлэн зуучлалын индексийг дараах томьёоны дагуу тооцно.

$$\text{Success Mediation Index} = \frac{\text{Number of successful mediations}}{\text{Number of mediations}} \times 100$$

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдсан буюу талууд эвлэрсэн тохиолдлын дунджийг тооцоолсоноор эвлэрүүлэн зуучлалын тогтолцооны үр нөлөө ямар түвшинд байгааг тандах боломжтой болдог. Хэдий эвлэрүүлэн зуучлалд хандах тоо хэмжээ өндөр байгаа ч эвлэрэл амжилттай болоогүйгээс эргээд шүүхэд ханддаг байвал тухайн бүс нутаг дахь эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо төдийлөн үр дүнгүй байх бөгөөд үүнийгээ дагаад шүүхийн ачаалал мөн буурахгүй.

Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг Хүснэгт.1-д буй 2022 оны тоо баримтад тулгуурлан дээрх аргачлалын хүрээнд тооцож үзвэл матрицын III дахь хэсэгт хамаарч байгаа юм. Уг III дахь хэсэг нь тухайн бүс нутагт амжилт багатай, цөөн тооны эвлэрүүлэн зуучлал явагддаг гэх болохыг харуулдаг ба энэ нь бусад хэсэгтэй харьцуулбал эвлэрүүлэн зуучлалын хэрэгжилт хамгийн бага түвшинд байгааг илтгэдэг.

$$\text{Balanced Relationship Index} = \frac{22059}{45895} \times 100 = 48.06$$

$$\text{Success Mediation Index} = \frac{9373}{22059} \times 100 = 42.49$$



Эндээс үзэхэд Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөтэй байдлын үзүүлэлт нь 50 хувь (дундаж үзүүлэлт)-д хүрэхгүй байгаа ч 48 болон 42 хувийн харьцаатай байгаа нь эвлэрүүлэн зуучлалд хандах тоог нэмэгдүүлэх, улмаар эвлэрлийн хуувийг ч мөн нэмэгдүүлж байж матрицын II хэсэгт буюу үр нөлөөтэй эвлэрүүлэн зуучлалын тогтолцоотой улсын тоонд орох юм. Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалд хандаж буй тоо шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр хандаж буй тоотой харьцуулахад харьцангуй бага байгаа нь иргэд, олон нийтийн эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдлэгийн түвшинг илүү сайжруулах, хувийн эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх орон зай байсаар байгааг харуулж байгаа бол, эвлэрүүлэн зуучлалд хандсан нийт өргөдлийн тоотой эвлэрлийн хувийг харьцуулж үзэхэд талуудын эвлэрлийн амжилт бага байгаа нь үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх чадавхи сул байгааг харуулж байна. Тиймээс эдгээр үзүүлэлтийг ахиулж үр нөлөөтэй эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхийн тулд тодорхой өөрчлөлтүүдийг хийж, үүсээд буй асуудлыг шийдвэрлэх гарц гаргалцааг бий болгох шаардлагатай байна.

Дэлхийн олон улс орнуудад шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвүүд буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийг хөгжүүлж ирсэн. Тухайлбал Сингапур улсад 2017 оны шинэ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль[18] батлагдахаас өмнө манай улстай ойролцоо нөхцөл байдалтай буюу хувийн секторт байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүд болон хувь эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар байгуулсан эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжгүй, эвлэрлийн гэрээгээр үүрэг хүлээсэн тал үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд албадан гүйцэтгүүлэх боломжгүй байдаг байсан. Харин 2017 онд батлагдсан хуулийн хүрээнд дээрх байгууллага, хувь эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар байгуулсан эвлэрлийн гэрээг гэрээ байгуулснаас хойш 8 долоо хоногийн дотор шүүхийн шийдвэрийн нэгэн адил үйлчлэлтэй хэмээн бүртгүүлэх боломжтой болсон байна. [19] Ийнхүү Сингапур улс асуудлыг хуулиар шийдвэрлэх замаар хувийн секторт байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааг бэхжүүлсэн байна.

Тэгвэл бид ч мөн адил төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн баталсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах талаас нь анхаарч тодорхой өөрчлөлтүүдийг хийж чадвал Монгол дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны

[18] Mediation Act 2017 of The Statutes of The Republic of Singapore https://storage.egazette.gov.sg/getFiles?ct=statutes&yr=2021&filename=21rs8264.pdf

[19] М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он., 22 дахь тал.

үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын тогтолцоонд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвүүдийг дэмжиж, дутагдсан орон зайг олон улсын туршлагад үндэслэн нөхөх шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ

Манай улсын хувьд шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаатай харьцуулахад өндөр дүнтэй байгаа талаарх нөхцөл байдлын судалгааны дүгнэлт олонтаа гарсан. Өөрөөр хэлбэл шүүхийн болон эвлэрүүлэн зуучлах төвүүдийн одоогийн төлөв байдлаас үзэхэд Монголд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог хөгжүүлж, бэхжүүлэх хэрэгцээ шаардлага нэгэнтээ үүсээд байгаа билээ. Дээр дурьдсанчлан олон улсын туршлагаас харахад үр дүнтэй эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог бүрдүүлэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэж буй маргааны тоо болон эвлэрэл амжилттай болсон хэрэг маргааны тоог үндсэн хэмжигдэхүүн болгон авч үзэж байгаа ба уг хоёр хэмжигдэхүүнээр Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын нөхцөл байдлыг тооцсон дүнг одоогийн түвшнээс ахиулах, цаашлаад дэлхийн жишигт нийцүүлэх байдлаар сайжруулах нь зүйтэй байгаа юм.

Тиймээс дараах зорилго, зорилтод хүрсэнээр үүсээд буй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж судлаачдын зүгээс үзэж байна.

1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэж буй маргааны тоог нэмэгдүүлэх талаас
   - ➢ Шүүхээс гадуурх буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүтэц зохион байгуулалт, чадавхи, мэргэшсэн байдал зэргийг сайжруулахын тулд эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох;
   - ➢ Шүүхээр шийдвэрлэгдэж буй маргааны тоо болон эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж буй маргааныг тоог 1:1 харьцаанд хүргэх;
2. Амжилттай эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэх буюу эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг нэмэгдүүлэх талаас
   - ➢ Шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдээр дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, эвлэрлийн гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй бол албадан гүйцэтгэх боломжтой болох эрх зүйн орчныг нь бүрдүүлэх;
   - ➢ Хэрэг маргааны төрлөөс шалтгаалан эвлэрүүлэн зуучлагчийн чадварыг нэмэгдүүлэх

ГУРАВ. ТУХАЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТӨЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ

Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэхийн тулд бодлогын дараах хувилбаруудаар шалган үзэж, хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх аль эсвэл бодлогын өөр хувилбараар асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолж шийдвэрлэх боломжтой эсэх талаар дүгнэлт хийнэ. Үүнд дараах бодлогын хувилбаруудад шинжилгээ хийнэ.

3.1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;

3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

3.3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;

3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх;

3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;

3.6. Захиргааны шийдвэр гаргах;

3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг эрх зүйн зохицуулалтыг энэ чигээр үлдээвэл, нөхцөл байдал өөрчлөгдөх, сайжрах дүр зураг харагдахгүй байна. Тухайлбал төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төв 2014 онд Монголын худалдаа аж үйлдвэрийн тахимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч тус эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулдаггүй байснаар эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангагдахгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагддаггүй тул талууд дахин эхнээс нь шүүхэд маргаанаа шийдвэрлүүлэх сөрөг үр дагавар үүссэний улмаас тус төвийн үйл ажиллагаа зогссон байна.

Түүнчлэн, 2020 онд хийж гүйцэтгэсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар[20] Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр нөлөөний талаар судалгаа хийжээ. Үр дүнд нь "...өнөөдрийг хүртэл тус хуулийн хэрэгжилтийн гол цөм нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн байна. Өөрөөр хэлбэл шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус, мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй байна" гэж дүгнэжээ.

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны үйл ажиллагаа дахь эвлэрүүлэн зуучлал, эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг[21] хийсэн байна. Тус судалгааны дүгнэлтээр "...Эвлэрүүлэн зуучлалын тухай 2012 оны хуулийн 8 дугаар зүйлд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлж болохоор заасан ч бодит байдал дээр эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийн асуудлаас үүдэн иргэд, аж ахуйн нэгжүүд эдгээр эвлэрүүлэн зуучлах төвөөс илүүтэй шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандаж байна. Ихэнх төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна." хэмээн дүгнэсэн байна.

Дээрх судалгаануудын дүгнэлтээс үзвэл 2012 оны эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн зохицуулалтыг энэ хэвээр нь үлдээх буюу шинээр зохицуулалт хийлгүй орхих нь үр дүнд хүрэх бодлогын зөв шийдэл биш байна.

---

[20] Судалгааны захиалагч Жайка олон улсын байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл. Судалгаа гүйцэтгэгч: Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа.

[21] М.Мөнхнаран, "Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь" судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2023.12 сар.

3.2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх

2020 онд хийсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагч ажиллах зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа талаар дүгнээд дараах шалтгаан, хүчин зүйлүүдийг дурджээ. Үүнд: Нэгдүгээрт, олон нийтийн дунд шүүхээс бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах төвийн талаарх мэдээлэл байхгүй. Хоёрдугаарт, Тус эвлэрүүлэн зуучлах төвүүд нь үйл ажиллагаа явуулдаггүй. Гуравдугаарт, Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад шаардлагатай хатуу болон зөөлийн дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй (дотоод дүрэм журам тодорхойгүй, хаана байрладаг, эвлэрүүлэн зуучлагчийн мэдээлэл байхгүй зэрэг). Дөрөвдүгээрт, Эрх зүйн зохицуулалтын дутмаг байдлаас гэжээ.

Түүнчлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд хийсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр “Иргэд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас илүүтэйгээр мэдэж байх бөгөөд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээлэл хомс байх нь элбэг. Мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарын талаарх мэдээллээс илүүтэй эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хийгдсэн эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах онцлогоор нь шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг олонд таниулж, мэдээлэл хийдэг. Үүнээс үзвэл маргалдагч талууд олон нийтэд хандсан мэдээлэл сайтай, нэр хүнд сайтай шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас илүүтэйгээр сонгоход хүрдэг.” гэж дүгнэсэн.

Дээрхээс дүгнэж үзвэл төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа төдийлөн амжилттай хэрэгжихгүй байгаа нэг шалтгаан нөхцөл нь олон нийтийн мэдээлэл, мэдлэг хомс байдагтай холбоотой байна. Гэхдээ зохицуулалтын энэ хувилбараар буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн ч эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байх тул энэ аргыг дангаар хэрэглээд үр дүнд хүрэхээргүй байна.

3.3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх

Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх асуудал нь шууд утгаараа эдийн засагтай холбогдохгүй бөгөөд зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийгээд ямар нэгэн эерэг үр дүнд хүрэхээргүй байна.

3.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх

Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх асуудал нь шууд утгаараа эдийн засагтай холбогдохгүй бөгөөд төрөөс санхүүгийн интервенц хийгээд ямар нэгэн үр дүнд хүрэхээргүй байна.

3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх

Төрийн зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэх харилцаа энд явагдахгүй бөгөөд талууд өөрсдийн сайн дурын үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдах үндсэн зарчимтай билээ. Гэхдээ арилжааны буюу шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа нь төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулах нь дамжиггүй.

3.6. Захиргааны шийдвэр гаргах

Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэхэд захиргааны байгууллагаас захиргааны акт болон захиргааны гэрээ байгуулах замаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.

3.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, энэ төрлийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог ажиллуулахын тулд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна. Учир нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний 2020, 2023 оны судалгаагаар төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулагдсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг болох талаар дурдаж, энэ чиглэлд хуулийг өөрчлөх талаар дүгнэлтүүд хийгдсэн байна.

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд зааснаар хэрэв “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол тухайн асуудлыг зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно гэжээ. Иймд, өмнө хийгдсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны зөвлөмжид үндэслэн Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлж, хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Судалгааны энэ хэсэгт эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад хэрэгцээ шаардлагатай бодлогын асуудлуудыг тодорхойлж, бусад улс орнуудын эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг судалж, тодорхойлсон асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор харьцуулсан дүн шинжилгээг хийж, цаашид авч хэрэгжүүлж болох бодлогын хувилбаруудыг дэвшүүлэх болно.

4.1. Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо

Эвлэрүүлэн зуучлах үйл явц үр дүнтэй, тогтвортой байхын тулд эвлэрүүлэн зуучлалыг дэмжих, бүртгэх, магадлан итгэмжлэх, эвлэрүүлэн зуучлагч нарын ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх, бодлого тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зэрэг үйл явцыг тодорхой болгосон зохицуулалтын тодорхой тогтолцоотой байх нь чухал юм. Энэхүү зохицуулалтын тогтолцоо нь мэргэжлийн соёлыг нэмэгдүүлэх, зуучлалын үйл явцад итгэх иргэдийн итгэлийг бий болгох зэрэг чухал ач холбогдолтой.

Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо нь дэлхийн бусад улс орнуудад өөр өөр эрх бүхий этгээдэд хадгалагдаж, зохион байгуулагдаж байна. Зохицуулах байгууллагуудын гол чиг үүрэг нь бодлого боловсруулах, эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүртгэлээс авахуулаад магадлан итгэмжлэх, бэлтгэх,

давтан сургах, хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд дараах нийтлэг загварууд[22] байна.

- *Эвлэрүүлэн зуучлалын өөрийгөө зохицуулах этгээд буюу эвлэрүүлэн зуучлагчдын холбоо хэлбэрээр зохион байгуулагдах загвар*

  Тухайлбал Голланд улсад эвлэрүүлэн зуулагчдын холбоо энэ чиг үүргийг гүйцэтгэдэг. Тус улсад нэгдсэн нэг зохион байгуулалттай эрх бүхий этгээд байхгүй бөгөөд эвлэрүүлэн зуучлагчдын бүртгэлийг Эвлэрүүлэн зуучлагчдын холбоо эрхлэн гүйцэтгэдэг байна.

- *Хууль зүйн яамны харьяанд эвлэрүүлэн зуучлалын хэлтэс хэлбэрээр зохион байгуулагдах загвар*

  Тухайлбал Турк, Итали зэрэг улсад эвлэрүүлэн зуулалын зохицуулагч байгууллага нь хууль зүйн яамны харьяанд байдаг. Хууль зүйн яам нь эвлэрүүлэн зуучлалтай холбоотой бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах бөгөөд эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулж буй төвүүд болон хувь хүмүүсийг бүртгэх, магадлан итгэмжлэх, сургах, эвлэрүүлэн зуучлагчтай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авах зэрэг эрх хэмжээтэй байна.

- *Тусдаа бие даасан загвар буюу эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар байгуулагдсан бие даасан байгууллагын хэлбэрээр зохион байгуулагдах загвар*

  Тухайлбал Румын улсад Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл байдаг. Энэхүү зөвлөл нь 9 эвлэрүүлэн зуучлагчаас бүрдэх бөгөөд 4 жилийн хугацаатай сонгогддог. Зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагч болон төвүүдийг, бүртгэх, магадлан итгэмжлэх, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх зэрэг эрх хэмжээтэй. Мөн эвлэрүүлэн зуучлагчид холбогдуулан гаргасан гомдлыг шийдвэрлэх эрх хэмжээтэй байна.

- *Нэгдсэн зохицуулалт хийх төвлөрсөн эрх бүхий байгууллага байгуулдаггүй загвар*

  Тухайлбал Сингапур улс байна энэ төрөлд хамаарч байна. Бодлого тодорхойлох төвлөрсөн байгууллага, эрх бүхий этгээд байхгүй бөгөөд эвлэрүүлэн зуучлалын томоохон төвүүд нь өөрсдийн дотоод дүрэм, шалгууртай. Зах зээлийн зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Манай улсын хувьд дээрх загваруудаас ялгаатай нь Шүүхийн захиргааны бие даасан байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулсан Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлд эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах чиг үүргийг хуулиар олгосон байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зөвлөлийн бүрэн эрхийг жагсааж өгсөн байх боловч магадлан итгэмжлэх, хувь эвлэрүүлэн зуучлагчийг атестатчилах бүрэн эрхийг олгоогүй байна.

Гэтэл бусад улс орнуудад магадлан итгэмжлэх тогтолцоог цөөнгүй нэвтрүүлсэн байх бөгөөд ихэнх тохиолдолд тухайн улсын хууль зүйн яам магадлан итгэмжлэх байдлаар, эвлэрүүлэн зуучлалыг чанаржуулах, хариуцлагажуулах, улмаар олон нийтийн итгэлийг бий болгох, магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлалын төвөөр үйлчлүүлж эвлэрсэн бол тодорхой эрх зүйн давуу байдлыг олгох зэргээр магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлж, ашиглаж байна. Ингээд энэ талаар дараах хэсэгт дэлгэрүүлж үзье.

Магадлан итгэмжлэлийн ач холбогдол

[22] Comparative Study of the legal and institutional frameworks and best practices on commercial mediation with recommendations for the Republic of Serbia (2021)., p.61. file:///C:/Users/Acer/Downloads/2A.%20ENG%20Study%20on%20Commercial%20Mediation%20in%20Serbia%20-%20Jun21%20(1).pdf

Хувийн эвлэрүүлэн зуучлалын төвийг магадлан итгэмжлэхийн ач холбогдол нь тухайн эвлэрүүлэн зуучлалын төвөөр үйлчлүүлэгч талын итгэлийг бэхжүүлэх, хамгаалах болон эвлэрүүлэн зуучлалд эрх зүйн хүчин чадал олгох замаар ашиглахад хялбар болгох зорилготой байна.

Магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэхээс өмнө хувийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо өргөн хэрэглэгддэггүй, талууд маргаанаа шийдвэрлүүлэхэд зарим нэг хуулийн хязгаарлалт байжээ[23]. Тухайлбал бусдаас хөлс авах замаар бусдын хууль эрх зүйн асуудлыг шийдвэрлэх нь хуулиар хориотой, мөн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа эвлэрүүлэн зуучлалаар тасалддаггүй, зогсдоггүй зэрэг эрх зүйн хязгаарлалт байсантай холбоотой. Иймд эдгээр саад тотгорыг арилгаж, хувийн эвлэрүүлэн зуучлалыг дэмжихийн тулд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдсанаар талуудад эрх зүйн хувьд ашигтай нөхцөл байдлыг бий болгох (хөөн хэлэлцэх хугацаа тасалдах, зогсох), хуулиар шууд хязгаарласан хоригийг үгүй болгох шаардлагатай байж. Гэхдээ бүх хувийн эвлэрүүлэн зуучлалд энэ эрхийг олгох зохисгүй тул шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлалыг магадлан итгэмжлэх байдлаар эрх зүйн давуу талуудыг олгох болжээ.

Магадлан итгэмжлэлд орох эвлэрүүлэн зуучлалын төвд зөвхөн хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүд хамаарах бөгөөд шүүхийн болон захиргааны байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа үүнд хамаарахгүй байна.

Гэвч нөгөө талаасаа магадлан итгэмжлэлийн шалгууруудыг хэт өндөр тавих нь эргээд эвлэрүүлэн зуучлалын төвүүдийн хөгжилд саад болох, хүнд суртал бий болгох эрсдэлтэй. Улмаар эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх бус эсрэгээрээ тус тогтолцоог нураах шалтгаан болно гэсэн шүүмжлэл мөн байдаг байна.

Эндээс дүгнэхэд хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжлэх нь манай улс дахь эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог хөгжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх эсэхийг шийдвэрлэхийн тулд магадлан итгэмжлэх тогтолцоог хэрэгжүүлэх дараах бодлогын хувилбарууд байж болох юм.

А. Хууль зүйн яам магадлан итгэмжлэх

Хууль зүйн яам нь хувийн эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх эрхтэй улс орнуудаас Итали, Грек, Сингапур, Япон улсуудыг дурьдаж болох юм. Ингэхдээ хууль зүйн яам нь хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд эвлэрүүлэн зуучлалын төвийг шууд магадлан итгэмжлэх, эсхүл яамны дэргэд байгуулагдсан хорооны үйл ажиллагаагаар дамжуулан магадлан итгэмжлэх зэрэг арга хэлбэрийг сонгодог байна. Гэхдээ аль ч арга хэлбэрийг ашигласан эцсийн дүндээ магадлан итгэмжлэх эрх нь Хууль зүйн яаманд олгогдсон байдаг.

Тухайлбал Грек улсын туршлагаас авч үзвэл “Эвлэрүүлэн зуучлалын төв хороо” буюу манайхаар Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүлийг магадлан итгэмжлэх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна. Тус улсын Эвлэрүүлэн зуучлалын төв хороо нь 2018 оны 6 дугаар сард Хууль зүйн яамны сайдын тушаалаар байгуулагдсан бөгөөд шүүгч, төрийн албан хаагчид, эвлэрүүлэн зуучлагчдын 13 хүний бүрэлдэхүүнтэй, эвлэрүүлэн зуучлалтай холбогдох бүхий л асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий бүтэц юм.[24] Энэ талаар Грекийн 2019 онд батлагдсан Иргэний болон арилжааны маргааны тухай эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 10 болон 11 дүгээр зүйлд зохицуулагдсан байдаг. Тодруулбал хуулийн 11

[23] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。224 頁。

[24] Directive 2008/52/EC of the European Parliament and of the Council of 21 May 2008 on certain aspects of mediation in civil and commercial matters., p.82.

дүгээр зүйлд “Эвлэрүүлэн зуучлалын төв хороо нь эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй” гэж заасан байдаг. Мөн тус хороо нь эвлэрүүлэн зуучлалтай холбогдох асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор өөрийн үзэмжээр дэд хороодыг байгуулж болохоор хуульд заасан ба үүний дагуу дөрвөн дэд хороог байгуулж, тодорхой үүрэг чиглэлтэйгээр ажилладаг байна. Үүнд:

1)Эвлэрүүлэн зуучлагчдын бүртгэлийн асуудал эрхэлсэн хороо
2)Эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн асуудал эрхэлсэн хороо
3)Хяналт шалгалтын хороо
4)Эвлэрүүлэн зуучлалын магадлан итгэмжлэл хариуцсан шалгалтын дэд хороо

Эвлэрүүлэн зуучлалын магадлан итгэмжлэл хариуцсан шалгалтын дэд хороо нь эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй этгээдийг магадлан итгэмжлэх зорилгоор бичгээр болон аман шалгалтыг зохион байгуулдаг байна.

Итали улсад Хууль зүйн яам магадлан итгэмжилсэн эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах төв л зөвхөн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Өдгөө 600 орчим төрийн болон хувийн эвлэрүүлэн зуучлах эрх бүхий этгээдүүд энэ талын үйл ажиллагаа явуулж байна.[25]Ийнхүү магадлан итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан этгээдэд тухайн эвлэрүүлэн зуучлах төв нь Итали улсын хоёроос доошгүй бүс нутагт эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэх санхүүгийн болон үйл ажиллагааны чадавхитай, дор хаяж 500,000 еврогийн хариуцлагын даатгалтай, үйл ажиллагаа эрхлэх өөрсдийн гэсэн оффистой, багадаа таван эвлэрүүлэн зуучлагчтай байх шалгуурыг тавьдаг. Уг эвлэрүүлэн зуучлагчид нь 50 цагийн эвлэрүүлэн зуучлалын сургалтанд хамрагдаж, шалгалт өгч тэнцсэн байх шаардлагатай байдаг.

Харин Япон Улсын хувьд хувийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх зорилготойгоор магадлан итгэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлжээ. Хууль зүйн яамнаас магадлан итгэмжлэх бөгөөд хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүй хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүд болон хувь эвлэрүүлэн зуучлагчийг магадлан итгэмжилнэ. Магадлан итгэмжлэлийн шалгуур нь мэргэшсэн байдал, хараат бусаар шударгаар үйл ажиллагаагаа явуулах байдал буюу ашиг сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлсэн байдал, эвлэрүүлэн зуучлагч нь өмгөөлөгч биш тохиолдолд хууль зүйн зөвлөгөө авах боломжоор хангагдсан байдал, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулах процессын шаардлага хангасан дүрэм, журам тогтоосон байдал, нууцлалыг хадгалах байдал, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд гомдол гаргасан тохиолдолд гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам тогтоосон байдал зэрэг нийт 16 шалгуур үзүүлэлтийг тогтоож өгсөн байна.

Дээрхээс дүгнэж үзвэл магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, босго нь өндөр байх бөгөөд хууль зүйн яамнаас тусгай магадлан итгэмжлэлийн хороо байгуулах зэргээр тусгай бүтэц, орон тоог бий болгосны үндсэн дээр магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан шийдвэрлэдэг байна. Манай улсын хувьд Хууль зүй дотоод хэргийн яаманд эвлэрүүлэн зуучлалын асуудлыг хариуцсан нэгж, хэлтэс байхгүй бөгөөд, бусад асуудлаар магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа явуулж байсан туршлага, бүтэц зохион байгуулалт байхгүй байна. Хэрэв хувийн эвлэрүүлэн зуучлалыг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлж, хууль зүйн яаманд харьяалуулах бол хуулиар тогтоосон шинэ чиг үүргийг бий болгох бөгөөд тодорхой хэмжээний захиргааны зардал үүсгэхээр байна.

Б. ШЕЗ-ийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл магадлан итгэмжлэх

[25] Italian Ministry of Justice (2011) “Italian legislation on Mediation”, p.7.

Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.16 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг байгуулна. Ийнхүү Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг албан ёсоор байгуулж, “Эвлэрүүлэн зуучлагчдын Зөвлөлийг байгуулах болон загвар батлах тухай” 10 дугаар тогтоолыг гаргажээ. Уг хуралдаанаас хуульд заасны дагуу шүүгч, өмгөөлөгч, судлаач зэрэг таван хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийн гишүүдийг баталсан бөгөөд энэ нь Зөвлөлийн үйл ажиллагаа хуулийн дагуу хэрэгжих эрх зүйн үндсийг бий болгосон юм. Түүнчлэн мөн тогтоолоор эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, эвлэрлийн гэрээний болон мэдэгдэх хуудасны загварыг баталсан байна.

Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 5 сарын 5-ны өдрийн 110 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5 дугаар зүйлд тодорхойлогдсон.

Тодруулбал Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн эрхийг дараах байдлаар тодорхойлжээ. Энэхүү бүрэн эрхэд “эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, дүрэм, эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлс, урамшууллын журам, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрны стандартыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох, эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах, мөн Зөвлөлийн хуралдааны дэгийг тогтоох” зэргийг хамааруулжээ. Харин Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн 5 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, бүртгэх, бэлтгэх, мэргэшүүлэх, цаашлаад холбогдох дүрэм, журмыг боловсруулж эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах биелэлтэд нь хяналт тавих, Шүүхийн ерөнхий зөвлөлд хуулийн хэрэгжилтийн талаар арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Судалгааны 4.1 дэх хэсэгт авч үзсэнчлэн эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын байгууллага нь эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, бэлтгэх, бүртгэх, давтан сургах, холбогдох дүрэм журмыг боловсруулах, эвлэрүүлэн зуучлагчийн бүртгэлээс хасах, магадлан итгэмжлэх чиг үүргийг хамтад нь гүйцэтгэж, эдгээр чиг үүргүүдийг төвлөрүүлж өгсөн байсан. Энэ нь магадгүй эвлэрүүлэн зуучлал нь өөрөө маргааныг таслах эрхтэй байдаггүй, маргалдагч талууд өөрсдөө сайн дурын үндсэн дээр хэлэлцэж маргаанаа шийдвэрлэдэг зэрэг онцлогууд нь ашиг сонирхлын зөрчлөөс хол, ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэл бага байдагтай холбоотой байж болох юм. Тиймээс улс орнуудын туршлагад үндэслэн эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх тохиолдолд энэ эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлд олгож, бүрэн эрх дээр нь нэмж хуульчилж болох юм. Гэхдээ Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд үйл ажиллагаагаа явуулдаг, зөвлөлийн гишүүд бүгд ШЕЗ-өөс томилогддог, санхүүжилт, ажлын алба зэрэг үйл ажиллагаа нь шүүхийн захиргааны байгууллагаас бүрэн хамааралтай байна.

Иймм нөхцөл байдал нь шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлж, бэхжүүлэхэд эвлэрүүлэн зуучлалын бодлого тодорхойлох, эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах, ёс зүй сахилга хариуцлагын асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг олгох нь хэр зохимжтой вэ? Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулиар шүүхийн захиргааны байгууллагын дэргэдэх зөвлөлд иймм хэмжээний эрх мэдлийг олгох эрх зүйн зохицуулалт байгаа эсэх, бодлогын шийдлийн хувьд хэр оновчтой байх зэрэг олон асуулт урган гарна. Түүнчлэн бусад улс орны туршлагаас үзэхэд эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, ёс зүй, сахилга хариуцлага, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах асуудлыг хууль зүйн яам нь хариуцаж байгааг анхаарууштай. Наад зах нь шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын бодлого тодорхойлох асуудлыг ШЕЗ-ийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлах зөвлөл хариуцаж байгаа одоогийн тогтолцоог хэвээр хадгалж болох боловч, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын асуудлыг бусад улс орны нийтлэг жишгийн дагуу хууль зүйн яам шийдвэрлэдэг байдлаар бодлогын шийдэл гаргаж болох юм.

В. Магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэхгүй байх

Магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлснээр судалгааны өмнөх хэсэгт авч үзсэнчилэн, эвлэрүүлэн зуучлалыг дэмжих, хөгжүүлэх, олон нийтийн итгэлийг бэхжүүлж, эвлэрүүлэн зуучлалд хандах хандлагыг бий болгох, магадлан итгэмжлэгдсэн бол эрх зүйн тодорхой давуу талуудыг олгох зэрэг ач холбогдолтой байсан. Гэхдээ магадлан итгэмжлэх тогтолцоо нь эргээд хувийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо, хөгжлийг нь боомилох, тушаа болох эрсдэлтэй гэсэн шүүмжлэлийг мөн дагуулж байдаг. Хувийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй байгаа манай улсын хувьд одоогийн байдлаар магадлан итгэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлэх цаг нь болоогүй байж болох талтай. Өөрөөр хэлбэл хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүдийг байгуулагдах нөхцөл боломжийг нь хуулиар ханган өгч, тодорхой хугацаа өнгөрсний дараа магадлан итгэмжлэлийн тогтолцоог хэрэгжүүлэх байдлаар магадлан итгэмжлэлийн тогтолцоо хэрэгжих хугацааг хойш нь тавь өгөх байдлаар шийдвэрлэх боломжтой байна.

4.2. Эвлэрүүлэн зуучлалын төвийн зохион байгуулалт

Эвлэрүүлэн зуучлалын төвийн зохион байгуулалт ямар байх, хуулийн этгээдийн эрхтэй бие даасан байгууллага байх, аль эсвэл хуулийн этгээдийн эрхгүй төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх бүтэц зохион байгуулалт байх эсэх зэрэг бодлогын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ асуудал нь цаашлаад эвлэрүүлэн зуучлалын хөгжлийн чиг хандлагыг тодорхой болгох, хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүдийг хэрхэн яаж байгуулах, тэдгээрийн ангилал, бүтэц зохион байгуулалт, эвлэрүүлэн зуучлагчийн хараат бус байдлыг хангах зэрэг талаарх олон талын ач холбогдолтой суурь асуудал юм. Иймд дэлхийн бусад улс орнуудад эвлэрүүлэн зуучлалын төвүүдийг хэрхэн ангилан авч үзэж байгаа, ямар статустайгаар байгуулдаг зэргийг судалж үзье.

1. Эрхлэн явуулж буй субьектээр нь ангилах

Хамгийн ерөнхий ангиллын нэг хэлбэр нь эрхлэн явуулж буй субьектээр нь (1) шүүхийн, (2) захиргааны байгууллагын, (3) хувийн гэж ангилж болдог байна. Тухайлбал шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн дэд бүтэц, эвлэрлийн гэрээг шүүгчээр баталгаажуулах зэрэг давуу талуудыг бий болгодог. Гэхдээ нөгөө талаар шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлал нь процесс болон эвлэрлийн гэрээний уян хатан байдал, эвлэрүүлэн зуучлагчийг сонгох тал дээр тодорхой хэмжээний хязгаарлалт

байдаг сул талтай гэжээ. Манай улсын хувьд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг амжилттай хөгжүүлж байгаа.

Захиргааны байгууллага эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах зорилго нь тухайн эрхлэх асуудлын хүрээнд илүү үр нөлөөтэй хэрэгжихүйц шийдвэр боловсруулах болон маргаанаас урьдчилан сэргийлэх замаар бодлогын хэрэгжилтийг сайжруулах зорилготой[26] байдаг байна. Түүнчлэн "Бельги, Кени зэрэг улс орнуудад "administrative mediation" буюу захиргааны эвлэрүүлэн зуучлалыг татварын маргаанд хэрэглэдэг[27].

Хувийн эвлэрүүлэн зуучлалын хэлбэр гэдэг шүүхийн болон захиргааны байгууллагаас бусад эвлэрүүлэн зуучлалыг хамрах ойлголт бөгөөд өмнөх хоёр хэлбэрээс ялгаатай тал нь үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байдгаараа онцлог ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлалын үр дүнд үүсэх зардлыг талуудаас төлсөн хураамжаар санхүүжүүлэх нь багагүй хэмжээний зардлыг талуудад үүсгэнэ. Энэ нь талууд хувийн эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх, сонгоход нэг бэрхшээлыг бий болгох эрсдэлтэй. Нөгөө талаар талуудаас өөр этгээд зардлыг гаргах тохиолдолд, зардал гаргагч нь өөрт аль ойр хамааралтай талд ашигтай байдлаар зөвлөх зэргээр ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэл байдаг. Үүнээс үүдэн хувийн эвлэрүүлэн зуучлалыг хэн эрхлэн явуулж буйгаас нь хамаарч хувийн эвлэрүүлэн зуучлалыг үйлчилгээ үйл ажиллагааны төрлөөр ангилах хэлбэр, бие даасан хэлбэр, холимог хэлбэр гэж гурав ангилж болдог байна.

Үйлчилгээний төрлөөр ангилах хэлбэр гэдэг нь тодорхой төрлийн үйлчилгээний салбараар нь ангилж тухайн төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй эрхлэгчдээс бүрдэж, тэдгээр аж ахуй эрхлэгчдээс гаргасан зардлаар үйл ажиллагаагаа явуулдаг эвлэрүүлэн зуучлалын байгууллага юм. Улмаар тухайн төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн зах зээлд нийлүүлдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн гэрээний маргаанд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулах юм.

Энэ төрлийн эвлэрүүлэн зуучлалын байгууллага нь санхүүжилтээс гадна, ажиллах хүчний хувьд ч холбооний гишүүн аж ахуйн нэгжийн ажилтныг ажиллуулах тохиолдол байдгаас эвлэрүүлэн зуучлалын төвийн хараат бус байдал төвийг сахисан байдал алдагдах эрсдэл байдаг. Гэхдээ хувийн эвлэрүүлэн зуучлалын төв нь хэрэглэгчийн маргааныг эвлэрүүлэн зуучлах тохиолдолд, хэрэглэгч талд зардлыг үүрүүлэх нь хэрэгжихэд хүндрэлтэй тул маргааны нөгөө тал болох аж ахуй эрхлэгчээс тодорхой зардлыг гаргуулахгүй бол тухайн эвлэрүүлэн зуучлалын төв оршин тогтнох боломжгүй болно. Олон улсын хувьд ч мөн хэрэглэгчийн маргааныг эвлэрүүлэн зуучлах хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүд нь татаас дэмжлэгийг эс тооцвол аж ахуй эрхлэгч талаас шууд бус зардлуудыг гаргуулах санхүүжилтийн хэлбэрийг сонгон үйл ажиллагаагаа явуулах нь элбэг байна[28]. Улмаар энэхүү санхүүгийн хараат бус байдлыг даван туулж, сул талаа нөхөхийн тулд эвлэрүүлэн зуучлагчаар хараат бус өмгөөлөгч болон мэргэжилтнийг ажиллуулах, мөн эвлэрүүлэн зуучлалын төвийн удирдах албан тушаалд хараат бус хүнийг томилж ажиллуулах байдлаар, хараат бус бие даасан байдлаа хангаж ажилладаг байна.

---

[26] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。19 頁。

[27] М.Мөнхнаран, "Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь" судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2023.12 сар.

[28] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。213 頁。

Энэ төрлийн эвлэрүүлэн зуучлалын төвийн Япон улсын туршлага гэвэл Доголдолтой бүтээгдэхүүнтэй холбоотой маргаан шийдвэрлэх төвүүд[29] (Product liability center), санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглэгчийн гэрээтэй холбоотой маргаан шийдвэрлэх төв[30] зэрэг хэлбэрээр байгуулагдан хөгжиж байна.

Бие даасан эвлэрүүлэн зуучлалын төв нь хувийн эвлэрүүлэн зуучлалын үндсэн зохион байгуулалтын хэлбэр болдог байна. Бие даасан эвлэрүүлэн зуучлалын төв нь үйл ажиллагаагаа үйлчилгээний салбараас эс хамааралтайгаар явуулж, эвлэрүүлэн зуучлагч болон процессын хараат бус байдлыг хангаж ажилладаг онцлогтой. Бие даасан эвлэрүүлэн зуучлалын төвийг дотор нь тодорхой нэг бүлгийн дотоод маргааныг шийдвэрлэх бие даасан хэлбэр[31], Хуулийн мэргэжлийн холбоодын дэргэдэх бие даасан хэлбэр [32] , Бусад салбарын бие даасан эвлэрүүлэн зуучлалын хэлбэр [33] зэргээр төрөлжүүлэн байгуулж болдог байна.

Холимог хэлбэрийн эвлэрүүлэн зуучлалын төв гэдэг нь зардал, санхүүжилтийн хувьд үйлчилгээний төрлөөр ангилах хэлбэртэй төстэйгөөр тухайн үйлчилгээний салбарын оролцогчдоос санжүүжилтийг гаргуулах хэдий ч, эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны процесс нь бие даасан эвлэрүүлэн зуучлалын төвтэй ижил байдлаар явагдах буюу эвлэрүүлэн зуучлалийн процессын (тухайлбал, өмгөөлөгчдийн холбооны эвлэрүүлэн зуучлагдаас эвлэрүүлэн зуучлагч нь томилогдох) хувьд хараат бусаар үйл ажиллагаа явуулах баталгааг хангах зорилготой байна. Тухайлбал, Япон улсад банкуудын холбооны нэг банк үйлчлүүлэгчтэй маргаж байгаа тохиолдолд тодорхой хугацааны дотор маргаанаа эвлэрэн зөвшилцөх замаар шийдвэрлэж чадаагүй бол өмгөөлөгчдийн холбооны эвлэрүүлэн зуучлагчаар ажиллагаа явуулах байдлаар дүрэмдээ тусгаж өгчээ. Энэ тохиолдолд өргөдөл гаргагчийн тэмдэгтийн хураамж болон замын зардлыг банкуудын холбоо хариуцах ба эвлэрүүлэн зуучлагчийн зардал, хөлсийг маргалдагч талууд төлөхөөр зохицуулдаг байна[34].

Түүнчлэн хөдөлмөрийн маргаан, гэр бүлийн маргаан, иргэний маргаан, арилжааны маргаан, спортын маргаан зэрэг маргааны төрлөөс нь хамааруулж эвлэрүүлэн зуучлалын төвийг ангилан байгуулж байна. Тухайлбал манай улсад хэрэгжиж байсан туршлагаас үзэхэд Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв нь зөвхөн арилжааны маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж байсан ба гэр бүлийн болон хөдөлмөрийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах өргөдлийн хүлээн авдаггүй байсан бол, үндэсний спортын арбитрын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв нь зөвхөн спортын маргаантай холбоотой хэрэгт эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг байна.

Мөн, маргааны талуудын нийцтэй байдал болон эвлэрүүлэн зуучлалын процессыг удирдан явуулж буй эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйгээс бусад мэргэжлийн этгээд байх зэрэг нөхцөл байдлыг харгалзан ангилж болдог байна. Жишээ нь эрх зүйгээс бусад тусгай мэргэжлийн хүний мэдлэг шаардлагатай байх маргаанууд байх бөгөөд

---

[29] Гэр ахуйн цахилгаан барааны доголдлыг шийдвэрлэх төв, тээврийн хэрэгслийн доголдлыг шийдвэрлэх төв, эм эмчилгээний хэрэгслийн доголдлыг шийдвэрлэх төв, барилга байгууламжийн доголдлыг шийдвэрлэх төв, хэрэглэгчийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний доголдлыг шийдвэрлэх төв зэрэг

[30] Үүсмэл үнэт цаас, хөрөнгө итгэмжлэх үйлчилгээ, амьдарлын даатгал, гамшгийн даатгал зэрэг төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвүүд үйл ажиллагаагаа явуулдаг байна.

[31] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。216 頁。

[32] Мөн тэнд.

[33] Мөн тэнд.

[34] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。222 頁。

үүнд барилгын маргаан, эмчилгээний гэм хорын маргаан, оюуны өмчийн маргаан, зам тээврийн ослын нөхөн төлбөрийн хэмжээ үнэлгээг тогтоох маргаан зэргээр тусгай мэдлэг мэргэшил шаардлагатай байх тохиолдол байдаг бол талуудыг эвлэрлийн яриа хэлэлцээг дэмжих тусгай ур чадвар, техник эзэмшсэн байдлаар нь мөн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ангилдаг байна.

Манай улсын одоогийн эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно" гэж зааснаар хувийн эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар нээлттэй орхисон байна. Тухайлбал өмнөх хэсэгт авч үзсэнчилэн, үйлчилгээний салбар төрлөөр нь даатгагчдын холбооны дэргэд даатгалын маргааныг эвлэрүүлэн зуучлах төв, банкуудын холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв зэргээр үйл ажиллагааны салбараар нь байгуулж болох бол Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын төв, Монголын хуульчдын холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв, Монголын өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв зэргээр процессын болон эвлэрүүлэн зуучлагчийн хараат бус байдлыг хангасан бие даасан эвлэрүүлэн зуучлалын төвүүдийг байгуулж мөн болохоор байна.

Тэгвэл, хувийн эвлэрүүлэн зуучлалын төвүүд нь хуулийн этгээдийн эрхтэй байх эсэх асуудал хөндөгдөнө. Манай улсын өнөөдрийг хүртэлх туршлагаас үзэхэд эвлэрүүлэн зуучлалын төвийг хуулийн этгээдийн эрхтэй байгуулсан тохиолдол байхгүй байна. Гэхдээ дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйл зэргээс үзвэл хувийн эвлэрүүлэн зуучлалыг төвүүдийг хуулийн этгээдийн эрхтэй байхаар байгуулах боломжийг нээлттэй үлдээх нь зүйтэй байна.

4.3. Эвлэрүүлэн зуучлалын загварууд буюу эвлэрүүлэн зуучлалыг дэмжих арга механизмууд

Хувийн буюу төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг хөгжүүлэх, бэхжүүлэхийн тулд манай улсад ямар загвараар эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог системчилж, ангилж байгаа талаар дүгнэлт хийж, цаашид хэрхэн системчилж, ангилж авч үзэх талаар бодлогын шийдэлд хүрэх шаардлагатай байна.

Тухайлбал эвлэрүүлэн зуучлалыг идэвхжүүлэх, нэвтрүүлэх, бэхжүүлэх үүднээс, Европын парламентаас иргэний болон арилжааны маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарим асуудлын тухай дугаар 2008/52/ЕС зааварчилгаа[35] баталсан бөгөөд уг баримт бичигт Европын холбооны улс орнууд уг зааварчилгааг хэрэгжүүлэхдээ ашигласан эвлэрүүлэн зуучлалын дөрвөн өөр загварыг тодорхойлсон.

1. Сайн дурын эвлэрүүлэн зуучлалын загвар

Энэхүү загварын хувьд талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхийг харилцан зөвшөөрсний үндсэнд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагддаг. Өөрөөр хэлбэл ямарваа нэг маргаан гарсан тохиолдолд талууд маргаанаа юуны өмнө эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэхээр бие даан тохиролцсон байдаг бөгөөд энэ нь гэрээний чөлөөт байдлын зарчимтай уялддаг байна. Тиймээс энэхүү

---

[35] Directive 2008/52/EC of the European Parliament and of the Council of 21 May 2008 on certain aspects of mediation in civil and commercial matters. https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2008:136:0003:0008:En:PDF

загварын хувьд зөвхөн талуудын хүсэл зоригийн үндсэнд тулгуурлан хэрэгждэг гэдэг утгаараа хуулиар заавал нарийвчлан зохицуулах шаардлагагүй гэж үздэг байна. 2008 онд Европын парламентаас тус зааварчилгааг батлахаас өмнө Европын холбооны улс орнууд энэ загварыг ихээхэн ашиглаж байжээ.

Ийнхүү талууд өөрсдөө бие даан эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар маргаанаа эцэслэхээр сайн дураараа тохиролцож, уг ажиллагааг эхлүүлдэг учраас эвлэрэл амжилттай болох магадлал хамгийн өндөр хувьтай байдаг. Энэ нь уг загварын давуу тал болдог байна. Харин сул тал нь уг загварын хүрээнд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдахын тулд зайлшгүй талууд бүгд зөвшөөрсөн байхыг шаардах ба хэрэв нэг тал эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээс татгалзсан тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдахгүй байх нөхцөл байдалд хүрнэ. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлалд хандах тоо бага байдаг. Ингэснээр шүүхийн ажлын ачаалал их байх хандлагатай байна.

Мөн энэхүү загвар нь иргэд, олон нийтийн эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдлэг, мэдээлэл өндөр түвшинд хүрээгүй улс оронд хэрэгжүүлэхэд тохиромжгүй байдаг. Учир нь талуудын сайн дурын үндсэнд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагддаг учраас шийдвэрлэгдэх маргааны тоо төдийлөн их байдаггүй бөгөөд цаашлаад тухайн бүс нутагт иргэд олон нийт эвлэрүүлэн зуучлалыг сонгох соёлыг бий болгоход дорвитой хувь нэмэр оруулдаггүй байна. Үүнээс үзвэл энэхүү загварыг ашигласнаар эвлэрлийн түвшин өндөр байдаг ч эвлэрүүлэн зуучлалд хандах тоо бага байдаг. Сайн дурын эвлэрүүлэн зуучлалын загварыг Австри, Бельги, Кипр, Эстон, Финланд, Франц, Герман, Латви, Литва, Люксенбург, Голланд, Португал, Руминь, Спани, Швед, Их Британи зэрэг европын ихэнх улс орнууд арилжааны болон иргэний эвлэрүүлэн зуучлалд ашиглаж байна.

Түүнчлэн шүүхийн ачаалал ердийн түвшнээс хэтэрсэн бүс нутагт энэ загвараар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад зохимжтой биш байдаг гэжээ. Тухайлбал, Монгол Улс дахь Иргэний хэргийн шүүхийн ажлын ачааллыг тооцсон 2018 оны судалгаанаас[36] авч үзвэл дүгнэлт хэсэгтээ “...нэг шүүгч дунджаар 200 хэрэг жилдээ шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай, үндэслэл бүхий шийдвэр гарна гэж” дүгнэжээ. Гэтэл 2022 оны шүүн таслах ажиллагааны дүн мэдээнээс үзвэл дүүргийн иргэний хэргийн нэг шүүгчид дунджаар 435 хэрэг ноогдож байсан бол төвийн 6 дүүргийн нэг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 шүүгчид 547 хэрэг ногдож байгаа[37] нь байх ёстой ажлын ачааллаас 2-2.5 дахин их байна. Тиймээс шүүхийн ажлын ачаалал өндөр, иргэдийн эрх зүйн мэдлэг, эрх зүйн ухамсрын түвшин зэргээс шалтгаалан Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын энэхүү загварыг ашиглахад тохиромжгүй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл шүүхийн ажлын ачааллыг бууруулахын тулд сайн дурын загварыг ашиглах нь оновчтой бодлогын хувилбар биш бөгөөд тодорхой хэмжээнд эвлэрүүлэн зуучлалд хандах сэдэл хөшүүргийг бий болгож өгөх хэрэгтэй байна.

2. Идэвхжүүлэлт болон хариуцлагажуулах тогтолцоо бүхий сайн дурын эвлэрүүлэн зуучлалын загвар

Европын холбооны гишүүн улс орнууд 2008 оны зааварчилгаа батлагдсанаас хойш эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх зорилгоор сайн дурын эвлэрүүлэн зуучлалын загварыг урамшуулал болон хариуцлагын механизмтай хослуулан хэрэгжүүлж эхэлжээ. Энэ загвараар санхүүгийн хувьд талуудад дэмжлэг үзүүлэх, мөн эвлэрүүлэн зуучлалд

---

[36] Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүхийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан”, УБ 2018 он., 62 дахь тал.

[37] Монгол Улсын шүүхийн 2022 оны шүүн таслах ажлын дүн мэдээ. 64 дахь тал. https://drive.google.com/file/d/1J4tKAxBPUJLvUQHIbc2O0_B4YPbD7doA/view

хандсан ч ажиллагаанд идэвхтэй оролцоогүй талд хариуцлага хүлээлгэх замаар эвлэрүүлэн зуучлалыг идэвхижүүлэх зорилготой. Тухайлбал Болгар, Латви улсуудад сайн дурааараа эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмаар маргаанаа шийдвэрлэх хүсэлт гаргаж, талууд эвлэрсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгодог байна. Мөн Итали улсад эвлэрүүлэн зуучлалд 500 евро хүртэлх улсын тэмдэгтийн хураамж төлсөн бол татварын хөнгөлөлт эдлэх зэргээр эвлэрүүлэн зуучлалыг дэмждэг байна.

Харин Эвлэрүүлэн зуучлалын анхны уулзалтад оролцохоос үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд тухайн талд хариуцлага оногдуулахаар заасан байдаг нь талуудыг үүрэгжүүлэх байдлаар эвлэрүүлэн зуучлалыг ашиглах нөхцөл боломжийг бий болгож өгчээ. Жишээ нь Унгар болон Их Британид шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх гэж оролдсон гэдгээ баримтад үндэслэн шүүхэд нотлох ёстой бөгөөд тус нотлох баримтаа гаргаагүй тал нь шүүхийн шийдвэр хэрхэн гарсанаас үл хамааран нөгөө талын төлөх улсын тэмдэгтийн хураамжийг хариуцаж төлөх ёстой байдаг.

Энэ төрлийн загварыг Европын улс орнуудаас Хорват, Эстон, Грек, Унгар, Ирланд, Итали (арилжааны болон иргэний маргааны 92 хувьд нь ашигладаг), Мальт, Польш, Словак, Словен зэрэг улс орнууд арилжааны болон иргэний маргаан дахь эвлэрүүлэн зуучлалд ашигладаг[38] байна.

Энэ загварын хувьд тухайн бүс нутагт заавал эвлэрүүлэн зуучлалын тухай бие даасан хуультай байх шаардлагатай гэж үздэг байна. Монголын өнөөгийн нөхцөлд энэ загварыг шууд хэрэглэхэд тохиромжтой бус байж болох юм. Учир нь Монголд эвлэрүүлэн зуучлал үр нөлөөтэй явагдахад дутагдаж буй орон зай нь хувийн эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа. Хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжөөгүй, эвлэрүүлэн зуучлалын төвүүд байгуулагдаагүй байгаа энэ цаг үед энэ загварыг хэрэглэх нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ачааллыг огцом нэмэгдүүлэх, улмаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа доголдох зэргээр сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байна. Гэхдээ энэ аргыг хуульчилж өгсөн тохиолдолд хууль хэрэгжиж эхлэх хугацааг хангалттай урт олгож, бэлтгэл хангасаны үндсэн дээр хэрэгжүүлж болох юм.

3. Эвлэрүүлэн зуучлалын эхний уулзалтад талуудыг зайлшгүй оролцохыг шаарддаг загвар

Энэхүү загвар нь сайн дурын эвлэрүүлэн зуучлал болон эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар зайлшгүй ашигладаг загварыг хослуулсан шинжтэй, шүүхээр хянан шийдвэрлэгдэх маргаан болон эвлэрүүлэн зуучлалд хандсан маргааны тоог тэнцвэржүүлэх ач холбогдол бүхий загвар юм. Энэ загварын хувьд дараах гурван нөхцөлийг хангасан байх ёстой гэж үздэг.

а. Эвлэрүүлэн зуучлалын эхний уулзалтыг зайлшгүй зохион байгуулах: Нэгдүгээрт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны анхны уулзалтаар тус ажиллагааны үр дүнтэй эхлэлийг хангах шаардлагатай гэж үздэг. Өөрөөр хэлбэл талууд эвлэрүүлэн зуучлагчтайгаар анхны уулзалтыг хийх ач холбогдол нь цаашид эвлэрэх ажиллагаа амжилттай явагдах үндэс суурь болдогтой холбоотой. Учир нь талууд тухайн асуудлаар харилцан ярилцаж ойлголцоогүйгээс жижиг маргааныг даамжруулж байдаг бөгөөд анхны уулзалтыг амжилттай зохион байгуулсанаар талуудад эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлалын ач холбогдолтой байдлыг тайлбарлаж, үр ашиггүй их хэмжээний зардал гаргах зэргээс сэргийлдэг байна.

[38] Directive 2008/52/EC of the European Parliament and of the Council of 21 May 2008 on certain aspects of mediation in civil and commercial matters., p.12.

Тиймээс анхны уулзалтыг амжилттай зохион байгуулахын тулд зардлыг боломжит хамгийн багаар тогтоох, эсхүл үнэ төлбөргүй болгож төсвөөс хариуцах зэргээр түлхэц үзүүлдэг.

б.Эхний уулзалтанд заавал мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийн эрхтэй этгээд оролцох: Хоёрдугаарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны анхны уулзалтанд мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч оролцохыг шаарддаг байна. Учир нь эвлэрүүлэн зуучлагч нь тодорхой ур чадварыг эзэмшсэн мэргэшсэн этгээд байх тул талуудыг эвлэрэхэд бодит дэмжлэг үзүүлдэг байна. Талуудад эвлэрүүлэн зуучлалын аргаар маргааныг эцэслэх нь хамгийн бага зардлаар хугацаа хэмнэж маргааныг шийдвэрлэж боломж гэдгийг мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч тайлбарлаж өгсөнөөр талуудын эвлэрэх магадлал тэр хувираа өсдөг байна.

в. Талууд эхний уулзалтын дараа эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанаас татгалзах боломжоор хангах: Гуравдугаарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний шатанд тус ажиллагаанаас татгалзах боломжийг талуудад олгохыг шаарддаг. Ингэхдээ ямар нэг хариуцлага ногдуулахгүй бөгөөд эхний уулзалтандаа оролцсоны дараа талууд эвлэрүүлэн зуучлалаас татгалзах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал бүрэн явуулах шаардлагагүй бөгөөд зөвхөн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчтай хуралдаанд оролцох үүргийг хүлээдэг. Энэ шаардлага нь талуудыг хариуцлага хүлээхгүйн тулд эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээр хуурамчаар эвлэрүүлэн зуучлагчид хандах сөрөг хандлагаас сэргийлэх зорилготой.

Энэ төрлийн арга механизмыг Чех, Итали зэрэг улс орнууд арилжааны болон иргэний эвлэрүүлэн зуучлалд ашигладаг бол, гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлалд Литва, Люксенбург, Их Британи зэрэг улс орнууд эхний уулзалтыг заавал эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотой явуулсан байхыг шаарддаг байна. Харин хөдөлмөрийн эрх зүйн маргаанд энэ загварыг ашигладаг Европын улс орон байхгүй байна.

Манай Улсын хувьд энэ загварыг шууд ашиглах боломжгүй байна. Учир нь хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжөөгүй байгаа нөхцөлд арилжааны болон иргэний бүх маргаанд эвлэрүүлэн зуучлалын эхний уулзалтыг зохион байгуулсан байх шаардлагыг тавих нь одоогийн шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэд бүтэц, хүн хүчний хувьд дааж давахгүй их ачааллыг бий болгож, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулна. Харин Итали улс шиг арилжааны болон иргэний маргааныг дотор нь ангилж тодорхой төрлийн маргааныг нэрлэн заах замаар энэхүү арга замыг ашиглаж болох юм.

4. Эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар ашигладаг загвар

Энэхүү загвар нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар эвлэрүүлэн зуучлал зайлшгүй явагдсан байхыг шаарддаг. Угтаа эвлэрүүлэн зуучлал нь сайн дурын байх үндсэн зарчимтай. Үүнээс улбаатайгаар энэхүү загвар нь шүүхэд хандахаас өмнө заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн байхыг шаарддаг учраас зарчмын хувьд зөрчилтэй гэх шүүмжлэлийг дагуулдаг. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдахад тохиромжгүй зарим төрлийн маргаан байх бөгөөд тус маргаануудад зайлшгүй эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хийсэн байхыг шаардах нь учир дутагдалтай юм. Гэвч нөгөө талаас эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зайлшгүй хийсэн байх тухай шаардлага нь тухайн хэргийг эвлэрүүлэн зуучлах замаар зайлшгүй шийдвэрлэх тухай шаардлага биш. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд талууд

эвлэрэхгүй байсан ч болох бөгөөд эвлэрлийн гэрээ зуун хувь талуудын хүсэл зориг, сайн дурын үндсэнд явагдана. Энэ нь уг загварыг зөвтгөх үндэслэл болдог.

Энэ загварыг Европын улс орнуудаас арилжааны болон иргэний маргаанд ашиглаж байгаа улс орон байхгүй байна. Гэр бүлийн эрх зүйн маргаанд Хорват, Унгар улсууд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн байхыг шаардаж байгаа бол, хөдөлмөрийн эрх зүйн маргаанд Австри, Хорват, Литва, Мальт зэрэг улсууд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан байхыг шаарддаг байна. Үүнээс дүгнэж үзвэл Европын улс орнууд арилжааны болон иргэний маргаанд сайн дурын эвлэрүүлэн зуучлах загварыг түлхүү хэрэглэж харин, гэр бүл болон хөдөлмөрийн эрх зүйн маргаанд цөөн хэдэн улс эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам болгож хуульчилсан нийтлэг байдал ажиглагдаж байна. Харин Япон Улсын хувьд байрны түрээсийн төлбөр, түрээстэй холбоотой маргаан, гэр бүлийн эрх зүйн маргааны тухайд гэрлэлт цуцлалттай холбоотой маргааныг зайлшгүй эвлэрүүлэн зуучлалаар урьдчилан шийдвэрлэдэг байхаар хуульчилж өгчээ. Учир нь байрны түрээсийн гэрээтэй холбоотой маргаан, гэрлэлт цуцлалттай холбоотой маргаан нь талуудын үргэлжилсэн шинжтэй хүн хоорондын харилцаанаас үүдэлтэй байх бөгөөд энэ төрлийн маргааныг шууд нэг шүүхээр нэг талын зөв буруу гэж шийдвэрлэхээс илүүтэйгээр талууд харилцан ярилцаж, ойлголцож асуудлыг шийдвэрлэх нь илүү зохистой маргааны төрөл гэж үзэж, шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнө талуудад ярилцах боломжийг бий болгох нь зүйтэй[39] гэж үздэг байна.

Манай Улсын хувьд гэр бүлийн эрх зүйн маргаанд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан байхыг шаардаж байгаа бол Хөдөлмөрийн тухай хуулиар сум дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор урьдчилан маргаанаа шийдвэрлүүлэх журмыг хуульчилж өгсөн. Гэхдээ хөдөлмөрийн хуульд заасан маргаан зохицуулах хороо нь талуудыг эвлэрүүлэн зуучлах чиг үүрэгтэй гэхээс илүүтэйгээр маргааныг таслах эрхтэй байхаар хуульд тусгаж өгсөн байна.

Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ” гэж, 6.4-т “Талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр гэрээндээ хэлэлцэн тохиролцсон бол шүүхийн бус аргаар урьдчилан шийдвэрлүүлэх журам тогтоосон гэж үзнэ” гээд, хуулийн 6.5-д “Энэ хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг зөрчиж нэхэмжлэл гаргасан бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасны дагуу уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэж хуульчилж өгсөнөөр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа зайлшгүй хийгдэх тохиолдлуудыг хуульчилж, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл болгож хуульчилсан туршлага байна. Иймд манай улсын хувьд хувийн эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, бэхжүүлэх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд таниулахын тулд тодорхой төрлийн арилжааны болон иргэний эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах урьдчилан шийдвэрлэх журам тогтоож, хүрээг өргөжүүлж болохоор байна.

4.4. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах арга замууд

Эвлэрлийн гэрээ нь маргаанд оролцогч талуудын хооронд үүссэн гэрээний эрх зүйн харилцаа бөгөөд уг эвлэрлийн гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотой асуудал нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Манай орны хувьд шүүхээс гадуурх

[39] 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」、日本評論社、2008 年。203 頁。

хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэнд батлагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах асуудал нь тодорхой бус байгаа билээ. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвийн ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлэх, эвлэрлийн гэрээг баталгаажуулах боломжит бодлогын хувилбаруудыг танилцуулъя.

А. Шүүхээр баталгаажуулах

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана" гэж заасны дагуу шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулахаар заасан бөгөөд энэ нь эвлэрлийн гэрээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх шинжтэй байна. Харин шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээг шүүх баталгаажуулахын тулд дараах хоёр төрлийн боломжит хувилбар байж болох юм.

1. Шүүгч эвлэрлийн гэрээг хянан баталгаажуулж захирамж гаргах

Шүүхээс гадуурх журмаар эвлэрэл амжилттай болж, эвлэрлийн гэрээ байгуулагдсан тохиолдолд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг шүүгч захирамж гарган баталгаажуулахтай адил процедураар тухайн эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангагддаг байдлаар зохицуулалт хийх боломжтой юм. Учир нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт амжилттай байгаагийн гол шалтгаан нь шүүгчийн захирамжаар эвлэрлийн гэрээ баталгаажиж, энэ нь эвлэрлийн гэрээний нэг тал үүргээ биелүүлээгүй тохиолдолд эвлэрлийн гэрээг шүүхийн шийдвэрийн нэгэн адил гүйцэтгэх үндэслэл болдогтой холбоотой. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй." гэснийг тус зүйлийн 27.2 дахь хэсэгт заасантай адил төстэй байдлаар өөрчлөн найруулж, шүүгч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хаана явагдсанаас үл хамааран эвлэрлийн гэрээг баталгаажуулдаг хувилбарыг хэрэгжүүлж болох юм.

Улс орнуудын туршлагаас авч үзвэл Йордан улсад талууд болон эвлэрүүлэн зуучлагч гарын үсгээ зурсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулсны үндсэнд гэрээний гүйцэтгэл хангагддаг бөгөөд энэхүү хандлагыг 2019 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөлдөө баримталсан. Мөн тус улсын хувийн эвлэрүүлэн зуучлалын онцлогоос дурьдвал шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах эрх бүхий субьект нь Хувийн Эвлэрүүлэн Зуучлах Төв /Private Mediation Centre/ гэх байгууллага байхаар хуулийн төсөлдөө зохицуулжээ. Өөрөөр хэлбэл шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын баталсан эвлэрлийн гэрээг шүүгч, шүүхээс гадуурх төвүүдийн баталсан эвлэрлийн гэрээг Хувийн Эвлэрүүлэн Зуучлах Төв баталгаажуулах чиг үүрэгтэй байхаар тус тусад нь зохицуулжээ.[40]

[40] European Bank for Reconstruction and Development (EBRD) and the International Development Law Organization (IDLO) (2022) "This Brief Guide to Commercial Mediation and Its Practice", p.15.

Энэ хувилбарыг ашиглахад тухайн эвлэрлийн гэрээний үндсэнд гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдөх эсэх асуудал үүсч болзошгүй бөгөөд гуравдагч этгээдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эвлэрлийн гэрээ хууль зөрчиж буй эсэх талаар хяналт тавих талаар тодорхой зохицуулалтыг хийх шаардлагатай.

2. Шүүхэд эвлэрлийн гэрээг бүртгэх

Улс орон бүр өөрсдийн онцлогоос шалтгаалан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбоотойгоор өөр өөр тохиромжит хувилбаруудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал Сингапур улсын 2017 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн[41] 12 дугаар зүйлд заасны дагуу шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр батлагдсан эвлэрлийн гэрээг шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх байдлаар авч үзэхийн тулд тухайн эвлэрлийн гэрээг шүүхэд гэрээ батлагдсанаас хойш 8 долоо хоногийн дотор эсхүл шүүхээс тогтоосон хугацааны дотор бүртгүүлсэн байхыг шаарддаг. Ингэхдээ тухайн эвлэрлийн гэрээг бүртгэхэд дараах гурван шаардлагыг зайлшгүй хангасан байх шаардлагатай гэж үздэг.

- Магадлан итгэмжлэгдсэн буюу хууль зүйн яаманд бүртгэлтэй хувийн эвлэрүүлэн зуучлах төв, эсхүл мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр тухайн эвлэрлийн гэрээ байгуулагдсан байх
- Эвлэрлийн гэрээ нь бичгээр хийгдсэн, талууд гэрээнд гарын үсгээ зурсан байх
- Эвлэрлийн гэрээнд байх зайлшгүй шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байх

Эдгээр шаардлагыг хангасан байх тохиолдолд шүүхээс эвлэрлийн гэрээг шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчинтэй гэж үзэж бүртгэхээр заасан байх ба шүүх эвлэрлийн гэрээг бүртгэх энэхүү механизмыг хуульдаа зохицуулах замаар Сингапур улс шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлалд тулгамдаад буй асуудлаа шийдвэрлэж чадсан байна.[42]

Гэвч манай улсад эвлэрлийн гэрээг шүүх бүртгэдэг тогтолцоог хэрэгжүүлэхэд төдийлөн тохиромжтой биш байна. Учир нь Монгол Улсад шүүх эрх мэдлийн гагцхүү шүүх байгууллага хэрэгжүүлэх бөгөөд энэ нь түүний шүүн таслах ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэх үндэслэл болно. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт Монгол Улсын Дээд Шүүх нь шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн тухай зохицуулсан ба 25.8.8-д улс төрийн намыг бүртгэхтэй холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ. Өөрөөр хэлбэл манай улсад шүүх байгууллага бүртгэлийн чиг үүрэг хэрэгжүүлэх тохиолдол нь зөвхөн Улсын Дээд шүүх “улс төрийн намыг бүртгэх” тохиолдол л байна. Үүнээс бусад асуудлаар бүртгэх үйл ажиллагааг манай улсын шүүх байгууллага явуулдаггүй.

Харин нөгөө талаасаа төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр батлагдсан эвлэрлийн гэрээг шүүхэд бүртгүүлэх замаар баталгаажуулах гарц нь Шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1-т заасанчлан Шүүхийн тамгын газар нь шүүхийн захиргааны удирдлагын дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ гээд 86.1.4 дэх хэсэгт “шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх” чиг үүргийг заажээ. Энэ заалтад буй агуулгаар шүүх нь эвлэрлийн гэрээг бүртгэх тухай хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн системд оруулсанаар

[41] Mediation Act of Singapore (2017) https://storage.egazette.gov.sg/getFiles?ct=statutes&yr=2021&filename=21rs8264.pdf

[42] М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он., 23 дахь тал.

тухайн эвлэрлийн гэрээг шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүлээн зөвшөөрдөг механизмыг бий болгож болох юм.

2015 оны 10 дугаар сараас эхлэн Шүүхийн ерөнхий зөвлөл болон Германы ОУХАН-ийн төслийн хүрээнд Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүлэн ашиглаж иржээ. Тус бүртгэлийн нэгдсэн систем нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн зарчмуудад тулгуурласан бөгөөд тухайн ажиллагааны нийт процесс буюу өргөдөл хүлээн авахаас эхлэн эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах хүртэл ажиллагаа хамаарах иж бүрэн дэвшилтэт цогц систем болжээ.[43] Энэхүү системийг ашиглаж шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг бүртгэх боломжтой байх бөгөөд уг бүртгэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг нь шүүхийн тамгын газрын дээр дурьдсан Шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1.4 дэх хэсэгт заасан чиг үүргийн дагуу тайлбарлагдах боломжтой.

Үүнтэй холбоотойгоор тухайн эвлэрлийн гэрээг хэн хянах, мөн хэн баталгаажуулдаг байх тухай асуудал урган гарч ирж болзошгүй. Эвлэрлийн гэрээг хянах, гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой энэ асуудлыг шийдэх арга зам нь шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжилж үйл ажиллагааг чанаржуулах, цаашлаад тухайн эвлэрлийн гэрээг сургалтанд сууж мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан байх зэргээр тухайн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг үүрэгжүүлэх замаар ажилдаа хариуцлагатай хандах нөхцөл боломжийг бий болгох боломжтой. Энэ нь шүүх эвлэрлийн гэрээг бүртгэдэг механизмыг Монголын хөрсөнд буулгаж хэрэглэх боломжит бодлогын хувилбар байж болох юм.

Б. Арбитраар баталгаажуулах

Монгол Улс 1994 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар Нью Йоркийн “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц”-д нэгдэн орсон. Тус конвенцоор нь гадаад улсад гарсан арбитрын шийдвэрийг дотоодын шийдвэрийн нэгэн адил хүчинтэй гэж үзэх бөгөөд арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэх журмыг тогтоосон. Мөн Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь хэсэг болон Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасны дагуу арбитрын шийдвэр нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болохоор заажээ. Эндээс үзэхэд Монгол Улсад гадаад, дотоод хаана гарсанаас үл хамааран арбитрын шийдвэр нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх шинжтэй байна. Тэгвэл эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг арбитрын шийдвэрээр баталгаажуулах замаар хангах дараах боломжит хувилбарууд байж болох юм.

1. Арбитрт талууд зэрэг хүсэлт гаргаж баталгаажуулах

Энэ механизмыг олон улсад Arb-Med гэж нэрлэх бөгөөд хялбараар арбитр болон эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг хослуулсан загвар гэж хэлж болох юм. Манай улсын хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээ нь хэн нэг этгээд баталгаажуулаагүй бол дангаараа гүйцэтгэл хангагдахгүй байх сул талтай бол Arb-Med механизмыг хэрэгжүүлсэнээр эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар эвлэрлийн гэрээ байгуулагдаж, арбитрын ажиллагааны үндсэнд тухайн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй болж буй юм. Энэхүү механизмын үр дүнд талууд маргаанаа эцэслэхэд заавал хоёр ажиллагааг давхардуулан цаг хугацаа, хөрөнгө мөнгөө үрэх шаардлагагүй байдаг. Өөрөөр хэлбэл хэрэв талууд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар

[43] ЛСА, Шүүхийн ерөнхий зөвлөл “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”, УБ 2020 он., 70 дахь тал.

тохиролцоонд хүрч чадахгүй эвлэрэл амжилтгүй болвол дахин арбитрт хандах гэж цагаа үрэх шаардлагагүй болдог. [44]

Монгол Улсын Арбитрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт "Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрсэн бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг дуусгавар болгох ба талууд ийнхүү хүсэлт гаргасныг арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаж баталгаажуулна." гэж заасан. Өөрөөр хэлбэл арбитрын ажиллагааны дуусгавар болох үндэслэл нь талуудын эвлэрэл байх бөгөөд ийнхүү эвлэрснийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаснаар талуудын хооронд байгуулагдах эвлэрлийн гэрээ нь арбитрын үндсэн шийдвэрээр баталгаажиж гүйцэтгэл нь хангагдах боломжтой болж байгаа юм.

Гэвч энэ нь талууд үүссэн хэрэг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэхээр арбитрын хэлэлцээр хийж, үүний дараагаар маргаан үүсч арбитрт хандсан, цаашлаад арбитрын ажиллагааны явцад эвлэрсэн этгээдүүдэд л хамааралтай байна. Өөрөөр хэлбэл шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээ бүр арбитрын үндсэн шийдвэрээр баталгааждаггүй буюу арбитрын шийдвэрээр эвлэрлийн гэрээ баталгаажих нь хумигдмал хүрээтэй байна.

Эндээс дүгнэвэл талууд эвлэрлийн гэрээгээ арбитрын шийдвэрээр дамжуулан баталгаажуулахдаа дараах үе шатаар дамжих боломжтой.

1)Талууд эвлэрлийн гэрээ байгуулах
2)Арбитрт хандах буюу нэхэмжлэл гаргах
3)Арбитрын ажиллагаа эхлэсэнээс хойш талууд эвлэрсэн тухай хүсэлтээ гаргах
4)Арбитрын үндсэн шийдвэр гарах (талуудын эвлэрэл, эвлэрлийн нөхцлийг тусгасан байх)

Хэдий энэ нь арбитрын ажиллагаагаар дамжуулан эвлэрлийн гэрээгээ баталгаажуулах олон үе шат дамжсан, шууд бус муйхар арга хэдий ч манай улс дахь өнөөгийн хууль тогтоомжийг өөрчлөхгүйгээр хэрэгжүүлж болох боломжит хувилбар юм. Шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулахад Арбитрын тухай хуульд буй арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрэх тухай дээрх заалтыг ашиглах боломжтой байна.

2. Эвлэрүүлэн зуучлалаас арбитрт шилжих

Харин Med-Arb буюу эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанаас арбитрт шилжих механизмыг хэрэгжүүлэхийн тулд талууд Med-Arb нь тодорхой маргааныг шийдвэрлэх процессын сонголт гэдгийг сайтар ойлгосон байх ёстой. Учир нь эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны үндсэн зарчим нь ажиллагаанд оролцогч талуудын нууцыг хадгалах байдаг.

Гэвч эвлэрүүлэн зуучлагч болон арбитрч нар нь нэг хүн байх тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд олж авсан талуудын хувийн чанартай нууц мэдээлэл арбитрын шийдвэрт ямар нэгэн байдлаар нөлөөлөх эрсдэл бий болдог. [45] Тиймээс энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа

---

[44] Mark Batson Baril, Donald Dickey (n.d) "MED-ARB: The Best of Both Worlds or Just A Limited ADR Option?" p.4 https://www2.mediate.com/pdf/V2%20MED-ARB%20The%20Best%20of%20Both%20Worlds%20or%20Just%20a%20Limited%20ADR%20Option.pdf

[45] Mark Batson Baril, Donald Dickey (n.d) "MED-ARB: The Best of Both Worlds or Just A Limited ADR Option" p.4.
https://www2.mediate.com/pdf/V2%20MED-ARB%20The%20Best%20of%20Both%20Worlds%20or%20Just%20a%20Limited%20ADR%20Option.pdf

амжилтгүй болвол арбитрчаар өөр этгээдийг сонгох эрхийг талуудад нээлттэй олгодог байх шаардлагатай юм.

Манай Улсын өнөөгийн эрх зүйн орчны хувьд эвлэрүүлэн зуучлалаас арбитрын ажиллагаа руу шилжих зохицуулалт байхгүй байгаа бөгөөд ирээдүйд арбитрын шийдвэрээр эвлэрлийн гэрээг баталгаажуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас арбитр руу шилжих энэхүү хувилбарыг сонголтот байдлаар нээлттэй үлдээх боломжтой гэж үзэж байна.

В. Нотариатаар гэрчлүүлж, нотариатын мэдэгдэх хуудсаар баталгаажуулах

Одоогийн ИХШХШтХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-т "...талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн гэрээг албадан гүйцэтгүүлэхээр бол … нотариатын мэдэгдэх хуудас … шүүхээр баталгаажсан байна." гэж хуульчилсан. Энэхүү заалт нь талууд гэрээнд үл маргах байдлаар үүргээ гүйцэтгэх талаар тохиролцож, үүнийгээ нотариатаар гэрчлүүлж, шүүхээр баталгаажуулснаар шууд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боломжийг олгосон зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл нотариатын мэдэгдэх хуудсыг шүүхээр баталгаажуулах нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга байх бөгөөд ингэснээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шилжих боломжтой.

Харин одоогийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нотариатын ажиллагаатай холбоотой зохицуулалт байхгүй буюу нотариатч чиг үүргийнхээ хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох боломжгүй байдаг. Тэгвэл талуудын хооронд байгуулагдсан эвлэрлийн гэрээг нотариатаар гэрчлүүлэн, нотариатын мэдэгдэх хуудсаар баталгаажуулж, гүйцэтгэлийг хангах нь үүсээд буй асуудлыг шийдвэрлэх нэг төрлийн бодлогын хувилбар байж болох юм.

Дэлхийн зарим улс орнуудад эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулах замаар гэрээний биелэлт хангагдах эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Тухайлбал Оросын холбооны улсад эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулсан тохиолдолд тухайн гэрээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх шинжтэй байхаар зохицуулжээ.[46] Мөн Австри, Хойд Македон, Монтенегро, Словени улсуудад аливаа эвлэрлийн гэрээ нь шүүхээр эсхүл нотариатаар баталгаажаагүй тохиолдолд хэрэгжих боломжгүй байдаг байна.[47] Өөрөөр хэлбэл улс орнууд нотариатаар дамжуулан эвлэрлийн гэрээг баталгаажуулах тогтолцоог хэдийнээ бүрдүүлжээ.

Эдгээр улсуудын дотроос Австри улсын тогтолцоог нарийвчлан үзвэл эвлэрлийн гэрээг Австрийн шүүхийн дэмжлэгтэйгээр байгуулсан, эсхүл нотариатад эвлэрлийн гэрээгээ бүртгүүлж шууд биелэгдэх шинж бүхий шийдвэрийн хэлбэрээр батлагдсан бол талууд тухайн эвлэрсэн асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргаж, маргаан үүсгэх боломжгүй байдаг байна. Харин шүүх болон нотариатаас гадна өөр байгууллага, эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл шууд хангагдах боломжгүй байдаг учраас энэ талаар талууд шүүхэд хандаж маргаанаа эцэслэн шийдвэрлүүлэх боломжтой байдаг.[48] Өөрөөр хэлбэл талууд эвлэрлийн гэрээг баталгаажуулахын тулд шүүхэд хандах, эсхүл аль хэдийнээ маргаанаа эвлэрлийн журмаар шийдэж эвлэрлийн гэрээ байгуулсан бол нотариатад хандан бүртгүүлэх замаар

---

[46] Robert Rinatovich Izmailov (2020) "Mediation in Russia: Law Enforcement Issues, Tendencies and Prospects" p.5

[47] Comparative Study of the legal and institutional frameworks and best practices on commercial mediation with recommendations for the Republic of Serbia (2021)., p.139.

[48] Walter H. RECHBERGER, "Mediation in Austria" (2015)., p.68.
https://www.ritsumei.ac.jp/acd/cg/law/lex/rlr32/rechberger.pdf

гүйцэтгэлийг хангах боломжтой. Эндээс эвлэрлийн гэрээг шүүхээр эсхүл нотариатаар баталгаажуулах аргын аль нэгийг сонгож хэрэглэх боломжтой байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн Япон улсад эвлэрлийн гэрээг мөн адил шүүх болон нотариатаар дамжуулан баталгаажуулсаны үндсэнд эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангагддаг бөгөөд үүний учир нь эвлэрлийн гэрээ нь зарчмын хувьд иргэний эрх зүйн хэлцэл учраас тухайн гэрээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил шууд биелэгдэх шинжийг агуулахгүй гэж үздэг байна. Ингэхдээ шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хандах, эсхүл тухайн эвлэрлийн гэрээнд талууд мөнгөн төлбөрийн үүргээ заавал гүйцэтгэх тухай, гүйцэтгээгүй бол албадлагаар гүйцэтгүүлж болох тухай заалтыг гэрээндээ тусгаж нотариатаар гэрчлүүлсэн байх ёстой байдаг.

Манай улсын Нотариатын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Талууд үл маргах журмаар төлбөрийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан нотариатаар батлагдсан гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг гаргуулахаар төлбөр авагчийн хүсэлтээр нотариатч мэдэгдэх хуудас үйлдэнэ” гэж заасан бөгөөд тус зүйлд мэдэгдэх хуудасны агуулга, үүнд тавигдах шаардлагын тухай хуульчилж өгсөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх хэсэгт заасны дагуу дээрх нотариатчын мэдэгдэх хуудас нь шүүхээр баталгаажсан байх тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болдог.

Эндээс дүгнэвэл манай улс эвлэрлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж, нотариатын мэдэгдэх хуудсаар баталгаажуулдаг механизмыг сонгон хэрэгжүүлэх тохиолдолд тухайн нотариатын мэдэгдэх хуудсыг шүүх баталгаажуулах шаардлагагүйгээр шууд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичиг болгох тал дээр анхаарлаа хандуулах шаардлагатай. Учир нь дээрх олон улсын туршлагатай харьцуулан үзвэл нотариатч тухайн эвлэрлийн гэрээг баталгаажуулсан л бол шүүхээр дахин баталгаажуулах шаардлагагүй байдаг нь эвлэрлийн гэрээг баталгаажуулах хоёр сонголтот хувилбар байгаа болохыг харуулж байна. Харин манай улсад нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болдоггүйтэй холбоотойгоор аливаа эвлэрлийн гэрээг нотариатч гэрчлэн, нотариатын мэдэгдэх хуудас үйлдсэн хэдий ч шийдвэр гүйцэтгэх шатанд биеллээ олохгүй байх сул талтай.

Тиймээс эвлэрлийн гэрээг нотариатчийн үйлдлээр баталгаажуулах хувилбарыг хэрэгжүүлэх тохиолдолд тухайн нотариатын баталгаажуулсан гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил шууд биелэгдэх шинжтэй байх талаас нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тодорхой заалтад нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй. Эвлэрлийн гэрээг нотариатийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэрээр баталгаажуулсан хэдий ч тус гэрээний гүйцэтгэл хангагдахын тулд шүүх дээр л баталгааждаг байх нь чанарын хувьд ялгаагүй нөхцөл байдалд хүргэнэ.

Г. Шүүхэд эвлэрлийн гэрээг түргэвчилсэн процедураар шийдвэрлэдэг байх

2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд ДолдугаарI бүлгийг нэмж өөрчлөлт оруулсан. Уг бүлгийн агуулга нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагатай тодорхой төрлийн хэрэг маргааныг тусгайлсан журмаар шийдвэрлэхээр заажээ. Тухайлбал шүүх хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхдээ зөвхөн нэг шүүх хуралдаанаар иргэний хэрэг үүсгэснээс хойш 45 хоногийн дотор шийдвэрлэх журамтай илүү түргэвчилсэн процесс бүхий ажиллагаа юм.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хувьд эвлэрлийн гэрээний баталгаажилтыг шүүгчийн захирамжаар баталгаажуулж шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчинтэй

байдлаар авч үзэж байгаа бол үүнтэй адилаар төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулан баталсан эвлэрлийн гэрээг мөн шүүгчийн захирамжаар баталгаажуулдаг хувилбар мөн өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжих боломжтой юм. Заавал ердийн журмаар бус түргэвчилсэн процедураар шийдвэрлэдэг байх нь энгийн үеийнхээс илүү хялбар, цаг хугацаа хэмнэсэн арга барил байж болох юм.

Эвлэрүүлэн зуучлах төвд хандан тодорхой хураамж төлсөн хэдий ч дахин шүүхэд улсын тэмдэгтийн хураамж төлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар эвлэрлийн гэрээг баталгаажуулах нь талуудын хувьд санхүүгийн хувьд төвөгтэй, олон шат дамжих процесс хэдий ч эвлэрлийн гэрээний гүйцэтгэлээ хангуулахын тулд шүүхээр тодорхой ажиллагаа хийлгүүлж, гэрээгээ баталгаажуулж байгаа гэдэг үүднээс хураамж төлөх нь зүй ёсны хэрэг юм. Харин уг хураамжийг ямар байдлаар тооцвох вээ гэдэг нь анхаарах ёстой асуудал юм. Хэт өндөр тогтоосноор эргээд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалтай шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагаа өрсөлдөх боломжгүй нөхцөл байдал хүрэх эрсдэлтэй юм.

Д. Эвлэрлийн гэрээг шууд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бичиг баримт болгох

НҮБ-аас Эвлэрүүлэн Зуучлах Ажиллагааны Үр Дүнд Хийгдсэн Олон Улсын Эвлэрлийн Гэрээний тухай Конвенцыг 2018 онд баталсан[49] бөгөөд уг конвенцын гол зохицуулалт нь мэргэшсэн, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах лицензтэй эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаатайгаар байгуулсан эвлэрлийн гэрээг Конвенцод нэгдэн орсон орнууд шүүхийн шийдвэрийн нэгэн адил үзэж хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал юм.

Энэхүү конвенцийн хүрээнд нэгдэн орсон улс орнууд нь өөрийн орны болоод хил дамнасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэнд байгуулагдсан эвлэрлийн гэрээг талуудад бичгээр гаргаж өгөх, уг гэрээг конвенцын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл холбогдох эрх бүхий байгууллагаараа дамжуулан гэрээний биелэлтийг хангах зэрэг үүргийг хүлээжээ. Тодруулбал конвенцын 4 дүгээр зүйлд эвлэрлийн гэрээнд талууд болон эвлэрүүлэн зуучлагч нь зайшгүй гарын үсэг зурсан байх, хэрэв цахим хэлбэрээр гэрээ байгуулсан бол талууд болон эвлэрүүлэн зуучлагчийг тодорхойлох баримт болон хүсэл зоригийг илэрхийлэх аргыг ашиглах шаардлагатай талаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл эдгээр шаардлагыг хангасан байх тохиолдолд тэрхүү эвлэрлийн гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэхээр зохицуулсан байна.

Олон улсын туршлагаас авч үзвэл Австри улсад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэнд батлагдсан эвлэрлийн гэрээнд албан ёсны тусгайлсан шаардлага тавигддаггүй бөгөөд энэхүү гэрээний гүйцэтгэл шууд хангагдах боломжтой байдаг. Харин Итали, Румын зэрэг улсуудад эвлэрлийн гэрээг заавал бичгээр хийж, эвлэрүүлэн зуучлагч болон талууд гарын үсэг зурсан байх зэрэг эвлэрлийн гэрээнд тавигдах дээр дурьдсан шаардлагуудыг хангасан тохиолдолд тухайн гэрээний гүйцэтгэл баталгааждаг байна.[50] Эндээс үзэхэд эвлэрлийн гэрээг байгуулахад зайлшгүй мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч оролцсон бол тухайн гэрээг шүүх, арбитр эсхүл нотариатч баталгаажуулах шаардлагагүй буюу гэрээ байгуулагдсан л бол шууд биелэгдэх шинжийг агуулж байна.

Энэхүү конвенцод Монгол Улс хараахан нэгдэж ороогүй байгаа бөгөөд шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн

---

[49] UNCITRAL (2018) “United Nations Convention on International Settlement Agreements Resulting from Mediation” https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/singapore_convention_eng.pdf

[50] European Bank for Reconstruction and Development (EBRD) and the International Development Law Organization (IDLO) (2022) “This Brief Guide to Commercial Mediation and Its Practice”, p.15.

гэрээг байгуулагдсан үеэсээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх шинжтэй гэж үздэг энэхүү хандлагыг төлөвшүүлэх нь эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх нэг бодлогын боломжит хувилбар мөн билээ.

4.5. Эвлэрүүлэн зуучлагчид тавих шаардлага

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилттай явагдах, цаашлаад талууд маргаанаа шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлалд хандан шийдвэрлүүлэх хандлага төлөвшин тогтоход эвлэрүүлэн зуучлагчдын ур чадвар, мэргэшсэн байдал зэрэг нь ихээхэн нөлөө үзүүлдэг учраас эвлэрүүлэн зуучлагч нь тодорхой шаарлагуудыг хангасан байх ёстой. Улс орон бүрт эвлэрүүлэн зуучлалын харилцаанд өөр өөр онцлог зохицуулалтуудыг хэрэглэж байна. Үүнээс ерөнхийд нь авч үзвэл эвлэрүүлэн зуучлагчийн мэргэжлийн ур чадвар дээр суурилсан эвлэрүүлэн зуучлалын төрөл загварууд бий болжээ.[51] Тухайлбал эвлэрүүлэн зуучлах ажиллагааг мэргэжлийн хүмүүс эсвэл шүүгчид дараах байдлаар хийж болно.

Мэргэжилтнүүдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа: Эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээг шүүх дэх болон шүүхийн гадна төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс (жишээ нь хуульч, нотариатч, нягтлан бодогч, шинжээч, тэтгэвэрт гарсан шүүгч) бие даан эвлэрүүлэн зуучлагчаар эсвэл төрийн болон хувийн хэвшлийн эвлэрүүлэн зуучлалын жагсаалтад орсон хүнээр үзүүлж болно. Мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагчдыг ихэвчлэн тухайн улсаас баталсан холбогдох дүрэм, магадлан итгэмжлэлийн схемийн дагуу эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг зохион байгуулахад магадлан итгэмжилж, эвлэрүүлэн зуучлагчын бүртгэлд бүртгэсэн байдаг. Энэ нь эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг бий болгож, түүний тогтвортой байдлыг хангаж, мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагчдын үзүүлж буй үйлчилгээний чанарыг баталгаажуулж буй нэг механизм юм. Улмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааны стандарт, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, зохистой цалин хөлс олгох журам зэрэг дүрэм журмыг тогтоож өгөх шаардлагатай байдаг.

Шүүгчдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа: Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүгч удирдан явуулж болно. Өөрөөр хэлбэл тухайн хэрэг маргаанд шүүгч нь эвлэрүүлэн зуучлагчаар оролцох бөгөөд ингэхдээ талууд өөрсдөө эвлэрэн хэлэлцэхээс илүүтэйгээр шүүгч тухайн маргаантай асуудлыг хуулийн хүрээнд үнэлэх байдлаар явагддаг.[52] Энэхүү хэлбэр нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлал бэхжихэд ихээхэн түлхэц үзүүлж, шүүгчдэд эвлэрүүлэн зуучлах арга техникт суралцах боломжийг олгодгоороо давуу талтай. Шүүгч нь эрх зүйн мэдлэгтэй, асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай, хуулийн хүрээнд шийдэл боловсруулж чадах мэргэшсэн этгээд байдаг тул тухайн асуудалд дүн шинжилгээ хийж, хуулийн хүрээнд үнэлэн шийдэл гаргаж байгаа нь шүүгчийн ур чадварт суурилсан эвлэрүүлэн зуучлалын нэг төрлийг бий болгож байна. Энэхүү ажиллагааны онцлог нь шүүгч өөрөө эвлэрүүлэн зуучлах ажиллагааг удирдан

---

[51] Brief guide to commercial mediation and its practices (2022) p.8. file:///C:/Users/Acer/Downloads/Brief%20Guide%20Design%20in%20English_June%202022.pdf

[52] 岡　英男（達）「 モンゴルの調停の特徴、土地紛争についての紛争解決と調停、日本の法整備支援によって導入された制度の定着に関する調査研究」34 項（2024 年）

явуулсаны үндсэнд хууль зүйн үндэслэл бүхий шийдлийг дэвшүүлдэг учраас бусад төрлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас түргэн шуурхай явагдах боломжтой байдаг.

Тухайлбал Япон улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь дээрх хэлбэрийн дагуу явагддаг бөгөөд ингэхдээ шүүгч нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг түргэн шуурхай, мэргэжлийн үүднээс явуулах зорилгоор хуульд заасан албадлагыг хэрэгжүүлэх боломжтой байдаг байна. Харин шүүхээс гадуурх буюу арилжааны шинжтэй эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд шүүгч бус тухайн салбарын мэргэжилтэн эвлэрүүлэн зуучлагчаар оролцдог учраас үнэлэх хэлбэрээр бус талууд өөрсдөө эвлэрэн хэлэлцэх боломжийг дэмжих байдлаар ажиллагаа явагддаг байна.

Эндээс үзэхэд эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар, мэдлэгээс шалтгаалан эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдах хэлбэр нь хоорондоо ялгаатай байна. Хэрэв тухайн ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцож буй этгээд нь эрх зүйн мэдлэгтэй, хуулийн хүрээнд талуудын маргаж буй гол асуудлыг үнэлэн шийдэл гаргах чадвартай байх тохиолдолд үнэлэх хэлбэрийн ажиллагаа явагддаг ба энэ нь ихэвчлэн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд ажиглагдаж байна. Харин бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч нь асуудлыг үнэлэх бус талуудыг өөрсдөө шийдэлд хүрэхэд дэмжлэг үзүүлэх замаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцдог ба энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч нь тодорхой нэг салбарт мэргэшсэн этгээд байдаг. Энэ төрлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ихэвчлэн арилжааны маргааныг шийдвэрлэх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдэд явагддаг.

Монгол Улсын хувьд шүүх дэх болон шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь үнэлэх хэлбэрээр бус талуудын эвлэрэн хэлэлцэх боломжийг дэмжих зарчмын хүрээнд хэрэгжиж байна.[53] Тодруулбал манай улс дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талууд өөрсдөө шийдэлд хүрэх, эвлэрүүлэн зуучлагч нь гагцхүү дэмжлэг үзүүлэх байдлаар ажиллагаанд оролцдог болох нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчмаас харагдаж байна. Тус зүйлд эвлэрүүлэн зуучлагч нь тухайн маргааны хүрээнд асуудлыг шийдвэрлэхэд төвийг сахиж, талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олох, хоорондох харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахаар заажээ. Ингэхдээ эвлэрүүлэн зуучлагч нь төрийн ямар нэгэн албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд зөвхөн талуудыг эвлэрэн хэлэлцэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.[54] Тухайлбал эвлэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлах үйл явцыг зохион байгуулах, удирдах, маргааныг шийдвэрлэх талаар талуудад амаар болон бичгээр зөвлөмж өгөх, талуудтай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт хийх, маргааныг хянан шийдвэрлэх хувилбарыг талуудад санал болгох, эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь талуудын тэгш оролцоог хангаж явуулах, талуудад эвлэрүүлэн зуучлалын үйл явц, түүний зорилго, үр дагаврын талаар мэдээлэл өгөх зэрэг хуульд заасан үндэслэл журмын дагуу дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

---

[53] 岡　英男（達）「 モンゴルの調停の特徴、土地紛争についての紛争解決と調停、日本の法整備支援によって導入された制度の定着に関する調査研究」90 項（2024 年）

[54] “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн тайлбар” УБ 2012 он., .. тал.

Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах нийтлэг шаардлагын тухай манай улсын хуулийн 9 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйн бүрэн чадамжтай, дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн, ял шийтгэлгүй этгээд байхаар зохицуулжээ. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн тухайд хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу эрх зүйч мэргэжилтэй байх шаардлагатай. Харин шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвийн зуучлагчид нь 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагыг хангасан байхаас гадна тухайн салбар, чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч байхыг шаардаж байна. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид нийтлэг шаардлагаас гадна эрх зүйч мэргэжилтэй байх тусгайлсан шаардлага тавигдаж байгаа боловч дээр дурьдсанчлан тэдгээрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, чиг үүргийн хувьд талуудын эвлэрэх боломжийг дэмжин ажиллаж байгаа тул манай улс дахь эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд талуудын эвлэрэн хэлэлцэх боломжийг дэмжих зарчим баримтлагдаж байна.

Энэхүү зарчмын хүрээнд нэгэнтээ аль ч эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд талуудын маргаан, санал зөрөлдөөнийг хуулийн хүрээнд үнэлэх ажиллагаа явагддаггүй учраас цаашид эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагыг эрх зүйч байх гэж тодорхойлох нь нэг талаараа туйлшралыг бий болгож байх магадлалтай. Учир нь эвлэрүүлэн зуучлагч талууд өөрсдөө шийдэлд хүрэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд гагцхүү тухайн чиглэлийн мэдлэгтэй, мэргэшсэн этгээд байх нь зүйтэй ба энэ нь бусад улс орнуудын сайн туршлагаас харагдаж байна. Тухайлбал Итали улсад эвлэрүүлэн зуучлагч нь Итали улсын Хууль зүйн сайдын 2010 оны 180 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн b-д заасан шаардлагыг хангасан байх ёстой. Тодруулбал их дээд сургууль төгссөн байх, эсхүл мэргэжлийн холбоо болон байгууллагын гишүүн байх шаардлагатай ба үүний дараагаар Хууль зүйн яамнаас магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагад хоёроос доошгүй жил сургалтанд хамрагдаж, хоёр жил дадлагажих шаардлагатай. Тус хугацаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэгдэж буй хориос доошгүй удаагийн маргаанд туслах эвлэрүүлэн зуучлагчаар оролцсон байх ёстой. Үүнээс үзэхэд зөвхөн эрх зүйч мэргэжлээр хязгаарлах бус харин тухайн салбарын орон зайг нь эвлэрүүлэн зуучлагчид тавьж өгч салбар салбарын мэдлэгтэй, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчдыг бэлтгэх нь тухайн төрлийн эвлэрэл амжилттай болоход түлхэц үзүүлнэ. Тиймээс манай улсад эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог бэхжүүлэхэд энэ салбарын гол түлхүүр болох эвлэрүүлэн зуучлагчдыг тодорхой бодлогын хүрээнд бэлтгэж, мэргэшүүлэх, цаашлаад тавигдах шаардлагыг өргөн хүрээнд тодорхойлох шаардлагатай байна.

Эвлэрүүлэн зуучлагчийн сургалтыг явуулах, эрхийн гэрчилгээ олгох үүргийг Хуулийн 11 зүйлийн 11.2, 11.3-д зааснаар Зөвлөл хүлээх ба Зөвлөлийн дангаар болон хамтран зохион байгуулсан сургалт байж болно. Ийнхүү Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах бөгөөд тухай этгээд нь эвлэрүүлэн зуучлагчийн сонгон шалгаруулалтад

тэнцэж, эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтад хамрагдан эвлэрүүлэн зуучлагчийн эрхийн гэрчилгээ авсан этгээд байна.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11.1.4-т зааснаар Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл эвлэрүүлэн зуучлагчдыг бүртгэж, нэрсийн жагсаалтыг хөтөлнө. Түүнчлэн тус хуулийн 11.3-т "энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага болон Шүүхийн ерөнхий зөвлөл эвлэрүүлэн зуучлагчийг сонгон бүртгэнэ..." гэдгээс үзвэл эрх бүхий байгууллага гэдэгт Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллагыг ойлгохоор байгаа ба эдгээр байгууллагын эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх ёстой байна. Ял шийтгэлгүй байх гэдгийг Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

Энэ зүйлд эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, журмыг ерөнхий байдлаар зааж өгсөн. Эдгээр дүрэм, журмыг Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс батлах эрхийг энэ заалт олгосон ба шүүхийн орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч нь эдгээрийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Харин төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоонд хамааралтай эвлэрүүлэн зуучлагчийн хувьд Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрмийг баримтлахаас гадна тухайн байгууллагаас баталсан журмыг үйл ажиллагаандаа баримтална гэсэн үг юм. Эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрмийг 2013 оны 8 сарын 7-ны өдөр баталсан. Хуульд зааснаар "бусад журам" гэдэг нь эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаанд холбогдон гарсан журмыг ойлгоно.

4.6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх маргааны төрөл хүрээг өргөжүүлэх эсэх

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3.1-т "Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн эрх зүйн маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ", мөн хуулийн 3.2-т "энэ хуулийн 3.1-д зааснаас бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэж болно" гэж хуульчилсан. Үүнээс үзвэл эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь хувийн эрх зүйн маргаанд хэрэгжих ба нийтийн эрх зүйн маргаан болох захиргааны эрх зүйн, эрүүгийн эрх зүйн маргаанд хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэх боломжтой байдлаар нээлттэй байдлаар зохицуулж өгчээ.

Хуульд тусгайлан заасан тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын тухай хууль ямар байдлаар үйлчлэх нь тодорхойгүй ч, эвлэрүүлэн зуучлалын хууль нь эрүүгийн хэрэгт ч мөн үйлчлэх үү гэдэг асуултад хариулах хэрэгтэй болно. Гэтэл иргэний, захиргааны болон эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам нь нийтийн болон хувийн эрх зүйн ялгаанаас хамаарч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, зарчим нь үндсэндээ өөр өөр байдаг байна. Тухайлбал, хувийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд мөрдөгдөж буй тодорхой зарчмууд нь эрүүгийн хэргийг эвлэрүүлэн зуучлахад хамаардаггүй байна. Эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь өөрийн тусгайлсан зарчимтай, тусгай дүрэм журмаар зохицуулагдаж байдаг. Жишээ нь, хохирогч болон хүчирхийлэгчийн хооронд эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой тохиолдолд хохирогч болон хэрэг үйлдэгч тал хоёулаа зуучлуулах хүсэлтэй байх, үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн баримтыг зөвшилцөх шаардлагатай болдог. Эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхэд хохирогчийн эрх ашгийг хэрхэн хамгаалах, тусгах, хэрэг үйлдэгчийн үйлдлийг хэрхэн авч үзэх, ял завших нөхцөл байдал бий болох эсэх зэрэг эрүүгийн эрх зүйн онол, зарчмын

асуудлуудыг хөндөх шаардлагатай болох тул эрүүгийн хэрэг эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын хуулиас тусдаа хууль батлан гаргаж, эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулах шаардлагатай.

Харин нийтийн эрх зүйд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэхдээ эвлэрүүлэн зуучлалын хуулиас тусдаа хууль батлах замаар хэрэгжүүлэх нь оновчтой байх бол хувийн эрх зүйн маргааны хувьд эвлэрүүлэн зуучлалыг нийтлэг хэрэглэж болох боловч, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг идэвхижүүлэх, одоо байгаа түвшнээс нэг шат ахиулахын тулд зарим төрлийн хувийн эрх зүйн маргаанд урьдчилан шийдвэрлэх журмыг тогтоон өгч маргааны төрөл хүрээг өргөжүүлэн өгч болох юм.

Монгол Улсад талууд хоорондоо маргааныг эвийн журмаар шийдвэрлэхээр тохиролцсон тохиолдолд, мөн гэр бүлийн маргаан шийдвэрлэх тохиолдолд урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар эвлэрүүлэн зуучлалыг ашиглах боломжтой. Тодруулбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ” гэж, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “...Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ” гэж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр гэрээндээ хэлэлцэн тохиролцсон бол шүүхийн бус аргаар урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ” гэж тус тус заасан бөгөөд дээрх 2 тохиолдолд Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтоосны илрэл болно.

Гэсэн хэдий ч шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны төрлөөс авч үзвэл талууд эвлэрэх боломжтой, бага үнийн дүн бүхий хэрэг маргаануудад урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам тогтоож өгсөнөөр шүүхийн ачаалал буурах, цаашлаад иргэдийн эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшлэх зэрэг давуу талтай. Гадаад орны сайн туршлагаас үзвэл Япон улсад түрээсийн гэрээ болон эд хөрөнгө хөлслэх гэрээтэй холбоотой маргаан талууд бусад төрлийн маргааны талуудтай харьцуулахад эвлэрэх магадлал өндөр байдаг тул энэ шинжид нь тулгуулан урьдчилан шийдвэрлэх журмыг тогтоож өгдөг байна.[55]

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан Монгол Улсын шүүхийн 2024 оны хагас жилийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээнээс үзвэл 2024 оны эхний хагас жилд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрэгт Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 26406 буюу 67.0 хувь, ИХШХШТХ-иар шийдвэрлэсэн хэргийн тоо 8264 буюу 21.0 хувь, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 3432 буюу 8.7 хувь, Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 461 буюу 1.2 хувь, Нийгмийн даатгалын багц хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 139 буюу 0.4 хувь, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 201 буюу 0.5 хувь, Газрын тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо 58 буюу 0.1 хувь, бусад хуулиар шийдвэрлэсэн маргаан 518

[55] 民事調停手続きについて日本の裁判所のウェブサイトにある情報
https://www.courts.go.jp/saiban/syurui/syurui_minzi/minzi_04_02_10/index.html

буюу 1.3 хувийг тус тус эзэлжээ.[56] Үүнээс Иргэний хуулиар шийдвэрлэсэн хэрэг, маргаан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17097 хэргээр буюу 1.8 дахин өссөн байна. Иргэний хуулиар шийдвэрлэсэн нийт хэргийн 40.2 хувийг банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан, 17.3 хувийг зээлийн гэрээтэй холбоотой маргаан, 14.0 хувийг худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаан, 12.8 хувийг банкнаас олгох зээлтэй холбоотой маргаанууд тус тус эзэлж байна.[57]

Дээрхээс авч үзвэл Иргэний хуулиар шийдвэрлэсэн нийт хэргийн 53 хувийг банк бус санхүүгийн байгууллага, банкнаас олгосон зээлтэй холбоотой маргаан эзэлж байгаа нь өндөр хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн маргааны онцлог бол зээл олгогч тал нь арилжаа эрхлэгч байх тул арилжааны эрх зүйн маргаанд хамаарах бөгөөд маргаанаа түргэн шуурхай зардал багатайгаар шийдүүлж, хөрөнгөө эдийн засгийн эргэлтэд хурдан оруулахыг зорих нь дамжиггүй бөгөөд, зээлдэгч талтай субьектив байдлаар харилцах хандлага бага тул эвлэрэн хэлэлцэх боломж өндөртэй маргааны төрөл байж болохоор байна.

4.7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа бол урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар маргааныг хянан шийдвэрлэх үе шат бус, харин шүүх болон арбитрын журмаар маргаан хянан шийдвэрлэхтэй адил нэг төрлийн маргааныг хянан шийдвэрлэх бие даасан процессын ажиллагаа юм. Энэ ч утгаараа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай явагдахад хугацааг зохистой тогтоох нь чухал ач холбогдолтой байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71.1-д хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, энэ хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж, нийт 90 хоногийн дотор шүүгч хэргийг шийдвэрлэхээр байна. Түүнчлэн анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар хэрэг шийдвэрлүүлэх зэргээр хугацаа сунгах боломжтой. Мөн Арбитрын тухай хуулийн 15.5-д аль нэг тал нь арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилно. Мөн хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлүүдээр арбитрын шийдвэрийн тухайд үг үсэг, тооцоо, хэвлэлийн болон тэдгээртэй адилтгах бусад алдааг засуулах зэргээр 3 удаа хүсэлт гаргаж болохоор байгаа ба тус бүрд хүсэлт гаргах эрх нь 30 хоногийн дотор гэж заасан нь нийт 90 хоногийн хугацаа болж байна. Үүнээс гадна Арбитрын бүрэлдэхүүн шаардлагыг үндэслэлтэй гэж үзвэл түүнийг хүлээн авсанаас хойш 60 хоногийн дотор нэмэлт шийдвэр гаргана гэж заасан. Арбитрын тухай хуулийн 40.3-т заасны дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтийг уг шийдвэрийг хүлээж авсанаас хойш гурван сарын дотор гаргаж болох бөгөөд 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хүсэлт гаргасан тохиолдолд уг хүсэлтийг шийдвэрлэснээс хойш энэ хугацаа тооцогдоно. Иймд шийдвэр гарсанаас хойш 240 хоногийн дараа шийдвэрийг албадан биелүүлэх нөхцөл үүсч байна. Харин Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 20 дугаар 20.1 дэх хэсэгт заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах ба энэхүү хугацааг талуудын хүсэлтээр нэг удаа сунгаж болно. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэснээс хойш 60 хоногийн хугацаанд талууд эвлэрэн хэлэлцэх боломжтой бөгөөд энэхүү хугацаанд багтаж эвлэрлийн гэрээ байгуулаагүй тохиолдолд тус ажиллагаа дуусгавар болно. Эндээс харахад бусад маргаан

[56] Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2024 оны хагас жилийн мэдээ”, УБ 2024 он., 14 дэх тал.

[57] Мөн тэнд.

хянан шийдвэрлэх хэлбэрүүдтэй харьцуулахад Эвлэрүүлэн зуучлалын хугацаа нь харьцангуй бага байна. Угтаа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хугацааны хувьд богино, түргэн шуурхай, хямд зардалтай байх онцлогтой боловч талуудын эвлэрэх боломжит хугацааг олгож өгсөнөөр эвлэрэл амжилттай болох үр дагавартай байдаг байна.

Бусад улс орнуудын туршлагаас үзвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг талууд эвлэрэхэд боломжит урт хугацаагаар тогтоож өгсөн бөгөөд хуульд хугацааны хязгаарлалт хийх нь талуудыг эвлэрэн хэлэлцэх боломжид сөргөөр нөлөөлөх үр дагавартай гэж үзэж байна. Тухайлбал Итали улсад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа нь анх хүсэлт гаргаснаас хойш 4 сар байх бөгөөд уг хугацааг талууд харилцан тохиролцож сунгах боломжтой байдаг. Тус улсын хуульд хугацааг дуусгавар болгох талаарх зохицуулалтыг тусгаж өгөөгүй нь эвлэрүүлэн зуучлалын сайн дурын байх зарчимтай уялдаатай байдаг байна.[58] Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талуудын хүсэл зоригийн үндсэнд тулгуурлан хэрэгждэг гэдэг утгаараа сайн дурын байх зарчимд тулгуурладаг учраас хуулиар заавал хугацааны хязгаарлалтын талаар нарийвчлан зохицуулах шаардлагагүй гэж үздэг байна.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд ЕАБХАБ-ын Ардчилсан институт хүний эрхийн газраас өгсөн саналд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны сунгах хугацааг 30 хоногоос 45 хоног болгох нь зүйтэй талаар, мөн ажиллагаанд оролцож буй бүх тал үүнийг зөвшөөрч байвал ажиллагааны хугацааг хэд хэдэн удаа сунгах боломж олгох нь зүйтэй гэж зөвлөсөн байна.[59] Гадаад улсын хууль тогтоомж болон олон улсын байгууллагаас өгч буй санал зөвлөмжид үндэслэвэл эвлэрүүлэн зуучлалын хугацаа нь тухайн хэрэг маргааны төрлөөс шалтгаалан ялгаатай байх тул хуульд хугацааг нарийвчлан тодорхойлох боломжгүй бөгөөд талууд хүсэлт гаргасан тохиолдолд хугацааг сунгах боломжтой байдлаар буюу хугацааны дээд хязгаарыг тогтоохгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.

4.8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж

Эвлэрүүлэн зуучлалын давуу тал бол түргэн шуурхай, зардал багатайгаар маргаанаа шийдвэрлэх байдаг. Зардал багатай гэдэг нь маргааны талуудад бусад маргаан шийдвэрлэх албан ёсны механизм болох шүүхийн процесст оролцохоос бага зардал гарахаар байхыг ойлгоно. Шүүх хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэхэд гурван шатны шүүхийн бүтэц ажиллах, хатуу тогтоосон процессын журмын дагуу ажиллагаа хийгдэх, шүүхийн шат болгонд улсын тэмдэгтийн хураамж төлөх, нарийн процессын журам тогтоосон байдаг тул мэргэшсэн өмгөөлөгч хуульч ажиллуулах хэрэгцээ шаардлага гарах, хатуу тогтсон процессын журам, шүүхийн ажлын ачааллаас хамаарч цаг хугацаа их зарцуулдаг зэрэг олон хүчин зүйлээс хамаарч шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх зардал өндөртэй байдаг. Үүнтэй харьцуулахад эвлэрүүлэн зуучлал нь талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэх тул хүний нөөцийн зардал бага, эвлэрлийн гэрээ байгуулсан бол давж заалдах шатгүй, шүүхийн процессын хууль шиг хатуу тогтоосон процессын нарийн журамгүй тул түргэн шуурхай байх боломжтой зэрэг олон давуу талтай байна.

Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр талууд маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7(1) дугаар зүйлийн 7(1).1 дэх хэсэгт заасны дагуу 30000 төгрөгийн хураамжтай байхаар тогтоосон байна. Өөрөөр хэлбэл маргааны үнийн дүнгээс үл хамааран бүх маргаанд

[58] Italian Ministry of Justice (2011) “Italian legislation on Mediation”, p.14.

[59] ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ийн санал, дүгнэлт” (Саналын дугаар: JUD-MNG/362/2019), 2020.05.11., 14 дэх тал.

тэмдэгтийн хураамжид 30000 төгрөг байхаар зохицуулжээ. Энэ нь шүүхийн улсын тэмдэгтийн хураамжтай харьцуулахад 1.300.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй маргаанд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас өндөр байх боловч, 1.300.000 мянгаас дээш үнийн дүнтэй маргааны хувьд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамж бага байна. Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 07 дугаар тогтоолоор "Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам"-ийг шинэчлэн баталсан бөгөөд шинэчлэн батлагдсан журмын 27.4.б хэсэгт 1.300.000 төгрөгөөс бага үнийн дүнтэй маргаанд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1.1-т заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлөхөөр зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл 1.300.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй маргаанд эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамжийг 30 мянган төгрөгөөс бага байхаар журамлаж өгсөн байна.

Түүнчлэн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд үнийн дүн өндөр, хэдэн тэрбумын шаардлага бүхий маргаанд эвлэрэх тохиолдол цөөнгүй, үүнд ч мөн адил улсын тэмдэгтийн хураамж 30 мянган төгрөг байгаа нь хэт бага гэх шүүмжлэл байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 оноос хойш хэрэгжээд даруй 12 жил болсон ч улсын тэмдэгтийн хураамжийг эдийн засгийн нөхцөл байдал, инфляцитай уялдуулах байдлаар шинэчлэн тогтоогоогүй байна. Үүнээс дүгнэж үзвэл шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамжийг интервалтай болгох, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тэмдэгтийн хураамжийг шинэчлэн тогтоох хэрэгцээ шаардлагатай байна.

Харин төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар маргаанаа шийдвэрлүүлсэн тохиолдолд ажлын хөлс, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлс зэргийг төлөх шаардлагатай. Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлсийг талууд гэрээгээр тохиролцоно" гэж зааж өгсөнөөс өөрөөр шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын хураамж, зардал, хөлсний талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөөгүй байна. Практикт эвлэрүүлэн зуучлах төвүүд ажиллагааны хөлс, хураамжийг хэрхэн тооцдог байсныг авч үзвэл Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв үйл ажиллагаагаа явуулж байхдаа өөрийн дотоод дүрмээрээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардлыг тогтоож мөрдүүлж байжээ. Ингэхдээ 1-ээс 10 сая хүртэлх үнийн дүнтэй маргаанд 100 мянган төгрөг, 10-аас 100 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй маргаанд 250 мянган төгрөг, 100 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй маргаанд 500 мянган төгрөг, эд хөрөнгийн бус мөнгөн дүнгээр үнэлэх боломжгүй маргаанд 200 мянган төгрөгөөр тооцож зардлыг төлүүлдэг байжээ. Гэвч тус дүрэмд дээрх зардлыг хэрхэн төлөх, хэзээ төлөх, хэрхэн хуваарилах талаар нарийвчилсан зохицуулалтыг дүрэмдээ тусгаж өгөөгүй байна.

НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос 2021 онд Эвлэрүүлэн зуучлалын загвар хуулийг баталсан[60] бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлалын зардлын тухай зохицуулалтыг нарийвчлан тусгажээ. Загвар хуульд зааснаар эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны ерөнхий зардал болох эвлэрүүлэн зуучлагчийн хөлс, ажиллагаанд талуудын зөвшөөрлөөр мэргэжилтэн оролцуулах зардал, тэдгээрийн унаа тээврийн зардал, бичиг баримтын зардал зэргийг талууд харилцан тэнцүү хуваж төлөх ба харин талуудын аль нэгийн хүсэлтээр ажиллагаа явуулсан тохиолдолд тухайн тал холбогдон гарах зардлыг хариуцах байдлаар зохицуулжээ. Талууд зардлыг төлснөөр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэх ба явц дунд гарсан нэмэлт зардлыг эвлэрүүлэн

[60] UNCITRAL Model law on mediation., Article 6.

зуучлагч талуудаас тэнцүү хувааж шаардах эрхтэй байна. Хэрэв тухайн нэмэлт зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол эвлэрүүлэн зуучлагч ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл дуусгавар болгох хүртэл арга хэмжээг авч болно гэж заасан байна.

Харин Итали улсын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардлын тухайд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаатай холбогдон гарах зардлыг (төвийн зардал, өмгөөлөгчийн хөлс, шүүхээс томилогдсон шинжээчийн зардал зэрэг) талууд өөрөөр тохиролцоогүй бол тэнцүү хуваахаар зохицуулсан байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах өргөдөл гаргахтай холбоотой зардлыг уригч тал ажиллагаа эхлэхээс өмнө урьдчилан төлсөн байх шаардлагатай ба үүний тал хувийг уригдагч тал нь эхний уулзалтын дараа төлөх үүрэг хүлээдэг. Тухайн маргааны төрлөөс хамааран гарах үндсэн зардал ялгаатай байдаг учраас хураамжийг талууд эхний уулзалтаа хийсэний дараа цаашид эвлэрүүлэн зуучлах ажиллагааг үргэлжлүүлэх болсон тохиолдолд төлдөг байна. Хэрэв талуудын аль нэг нь төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон бол тухайн эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулж буй байгууллага нь зардлаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх асуудлыг хэлэлцэж болно.

Манай Улсын хувьд зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хураамжийн асуудлыг зохицуулж, шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын хураамжийн талаар нарийвчлан тогтоогоогүй байгаа нь тус хувийн эвлэрүүлэн зуучлалын салбар зах зээлийн зарчмынхаа дагуу өөрөө хөгжих боломжийг олгосон гэж үзэж болох юм. Харин эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдахад хураамжийг хэзээ, яаж, хэрхэн төлөх эсэх асуудлыг нарийвчлан тогтоогоогүй байгаа нь бусад маргаан шийдвэрлэх аргуудтай харьцуулахад тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Тиймээс эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан маргаанаа хянан шийдвэрлүүлэхэд ямар зардал үүсэх, түүнийг ажиллагааны аль шатанд төлөх зэрэг нь тодорхой болгох шаардлагатай байгаа бөгөөд энэ нь цаашлаад эвлэрүүлэн зуучлалыг сонгох хүмүүсийн тоог нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлалыг идэвхжүүлэхэд эерэг нөлөөтэй байна.

4.9. Эвлэрлийн гэрээнд зайлшгүй тусгах ёстой зүйлс

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “Эвлэрлийн гэрээ” гэж маргаан буюу тодорхой санал зөрөлдөөнтэй асуудалд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсаны үр дүнд талуудын хооронд бичгээр хийсэн хэлцлийг гэж, хуулийн 3.4-т талуудын хооронд үүссэн маргаан нь гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хөндөхөөр бол эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болохгүй гэж, хуулийн 26.4-т эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд хийгдсэн эвлэрлийн гэрээ Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байх хуулийн шаардлага тавигдаж байна.

Үүнээс үзвэл эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээ нь хууль зөрчөөгүй, гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй, нийтийн эрх ашгийг харшлаагүй байх шаардлага тавигдаж байна. Хэрэв эдгээр шаардлагыг хангаагүй гэрээ байгуулагдвал шүүгч баталгаажуулахгүй байх боломжтой байна. Хэрэв хуульд заасан шаардлага хангаагүй, аль эсвэл эвлэрлийн гэрээ нь гуравдагч этгээдийн эрх ашгийг зөрчсөн нөхцөл байдал хожим илэрвэл хэрхэн шийдвэрлэх асуудал хуульд тодорхой тусгаж өгөөгүй байна. Хуульд заасан шаардлагыг агуулгын болон хэлбэрийн шаардлага гэж ангилж үзвэл:

Хэлбэрийн шаардлагад эвлэрлийн гэрээг бичгээр хийж, гэрээг байгуулсан он сар өдөр, эвлэрүүлэн зуучлагчын овог нэр, хаяг, эвлэрүүлэн зуучлал эхэлсэн он сар өдөр, маргааны агуулга, маргааны талаарх талуудын байр суурь, гэрээгээр тохиролцсон

зүйлсийг тодорхой тусгаж, гурван талаас гарын үсэг зурж баталгаажуулна гэсэн байна. Хэлбэрийн шаардлагын хувьд эвлэрлийн гэрээнд маргааны талаарх талуудын байр суурийг тусгахыг шаардаж байгаа нь ойлгомжгүй байна. Нэгэнт эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талуудын тайлбар мэдүүлэг нь нууц байх, шүүх дээр нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй зэргээс үзвэл эвлэрлийн гэрээнд талуудын байр суурийг тусгах шаардлагагүй байна. Энэ талаар Европын холбооны Ардчилсан Институтын Хүний Эрхийн газраас Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд хийсэн дүгнэлтээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26.3-т заасан “талуудын маргаан, тэдний байр суурь болон бусад асуудал” гэсэн хэсгийг хасахыг санал болгожээ. Учир нь эдгээрийг эвлэрлийн гэрээнд тусгах нь нууцлалын асуудлыг зөрчиж болзошгүй бөгөөд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй талууд өөрсдийн байр суурь, асуудлуудаа гэрээнд баримтжуулан оруулах ёстой гэдгийг урьдчилж мэдсэнээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд нээлттэй оролцохгүй байх, өрийн хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэхгүй байх зэргээр болгоомжлол бий болж, улмаар эвлэрэл явагдахгүй байх эрсдэлтэй. Иймд эвлэрлийн гэрээ нь хэлбэрийн хувьд маш тодорхой байх шаардлагатай байна.

Харин агуулгын шаардлагын хувьд эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй, нийтийн ашиг сонирхолд харшлаагүй байх шаардлагыг хуульчилсан. Хэлбэрийн шаардлагын хувьд шүүгч хянаж баталгаажуулахад эргэлзэх зүйл байхгүй боловч агуулгын шаардлагыг яг таг хангаж байгаа эсэхийг шалгахад бэрхшээлтэй байж болох юм. Тухайлбал Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд эвлэрлийн гэрээг шүүгчээр баталгаажуулахад талууд болон эвлэрүүлэн зуучлагч бүгд биечлэн байлцах шаардлагатай эсэхийг зохицуулж өгөөгүй байна. Эвлэрлийн гэрээ нь иргэний хуульд нийцсэн байх гэсэн шаардлага байгаа учраас эвлэрлийн гэрээний талуудын хүсэл зориг, хүсэл зоригийн илэрхийлэл, үр дүн нэгдсэн байх шаардлагатай бөгөөд энэ үе шатыг эвлэрүүлэн зуучлагч талуудад дэмжлэг үзүүлэн хийгдэж буй процесс тул шүүгч гагцхүү эвлэрүүлэн зуучлагчид итгэж, найдахаас өөр аргагүй юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны үр дүнд Монгол Улс дахь эвлэрүүлэн зуучлалын салбар цаашид бие даан хөгжихөд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэж болох арга зам, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар бусад улс орны хуулийн онцлог зохицуулалтууд, сайн туршлагатай харьцуулан судлаж дараах дүгнэлт, саналыг гаргаж байна.

5.1. Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо

Өнөөгийн байдлаар Монгол Улсад шүүхийн захиргааны бие даасан байгууллага болох Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс байгуулсан Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй эрх бүхий этгээд байх ба эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зөвлөлийн бүрэн эрхийг жагсааж өгсөн байх боловч магадлан итгэмжлэх, хувь эвлэрүүлэн зуучлагчийг атестатчилах бүрэн эрхийг олгоогүй байна.

Угтаа Эвлэрүүлэн зуучлалын салбар цаашид тогтвортойгоор хөгжих, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь үр дүнтэй байхын тулд эвлэрүүлэн зуучлалыг дэмжих, бүртгэх, магадлан итгэмжлэх, эвлэрүүлэн зуучлагч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх,

бодлого тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зэрэг үйл явцыг тодорхой болгосон зохицуулалтын тодорхой тогтолцоотой байх нь чухал юм. Ингэснээр иргэдийн эвлэрүүлэн зуучлалын талаарх эрх зүйн мэдлэг ухамсар дээшилж итгэл бий болох, тус салбар дахь мэргэжлийн соёл дээшлэх, цаашлаад эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр маргаанаа богино хугацаанд бага зардалтайгаар шийдвэрлэх хэргийн хувь хэмжээ өсөх, шүүхийн ачаалал буурах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд өндөр ач холбогдлыг бий болгох юм.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Бодлогын шийдлийн хувьд шүүхийн дэргэдэх болон шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын удирдлагыг ялгаатай этгээдүүдэд хариуцуулах,
- Тодруулбал шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын удирдлагыг одоогийн хуульд зохицуулсаны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлд хэвээр хадгалах,
- Ингэхдээ шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын одоо хэрэгжиж байгаа тогтолцоог хэвээр хадгалж, Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдыг бэлтгэх, сонгон шалгаруулах, бүртгэх, гэрчилгээ олгох, давтан сургах, тэдгээрийн ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, сахилга хариуцлагын асуудлыг тодорхойлж хэрэгжүүлэх, шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны дүрэм журмыг боловсруулах зэрэг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай холбоотой бүхий л асуудлыг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулах,
- Харин шүүхийн бус хувийн эвлэрүүлэн зуучлалын удирдлагыг Хууль зүйн яаманд хариуцуулах,
- Хууль зүйн яамны дэргэд хувийн эвлэрүүлэн зуучлалын асуудал хариуцсан хороог байгуулж ажиллуулах. Тус Эвлэрүүлэн зуучлах хороо нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдаас бусад эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалт явуулах, давтан сургах, бүртгэх, зөвшөөрөл олгох, тэдгээрийн ёс зүй сахилга хариуцлагын асуудлыг шийдвэрлэх, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх эсэх талаар санал боловсруулж Хууль зүйн яамны сайдад хүргүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх,

Түүнчлэн магадлан итгэмжлэх, зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг бий болгоход дараах бодлогын хувилбарыг дэвшүүлж байна.

- Хууль зүйн яам нь бүтцийн хувьд өөрчлөлт орж зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий бие даасан хэлтсийг байгуулан дан ганц эвлэрүүлэн зуучлалын асуудлаар бус яамнаас зөвшөөрөл олгохтой холбоотой бүхий л салбарын асуудлаар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой байна. Тухайлбал Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу нотариатчийн чиг үүргийг гагцхүү зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх ба тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь хэсэгт заасны дагуу нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн олгоно. Үүний адилаар хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн шийдвэрлэх ба ингэхдээ Хууль зүйн яамны дэргэд Эвлэрүүлэн зуучлах хорооны санал дүгнэлтэд үндэслэх, эсхүл яамны бие даасан хэлтэс болох зөвшөөрлийн хэлтсээр дамжуулан дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой юм. Эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжилснээр хувийн эвлэрүүлэн зуучлалын салбарын чанарыг тодорхой стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх давуу талтай юм.

5.2. Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалтын талаар

Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалтын асуудал нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хуулийн этгээдийн эрхтэй, эрхгүй, мэргэжлийн холбоодын дэргэд, аль эсвэл бие даасан байдлаар байгуулагдах зэргээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалтын хэлбэрийг чөлөөтэй байдлаар тусгаж өгсөн байна. Энэ нь бодлогын зөв шийдэл байх бөгөөд харин төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулагдаж буй эвлэрүүлэн зуучлах төвийн онцлогыг харгалзан үзэж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх механизмуудыг сайтар тусгаж, үйл ажиллагааг нь зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал, мэргэжлийн холбоодын дэргэд буюу даатгагчдын холбооны дэргэд даатгалын маргааныг эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдаж болно. Энэ тохиолдолд даатгагчдын холбооны гишүүд нь даатгалын компаниуд буюу даатгагч нар байх бөгөөд холбооны үйл ажиллагааны санхүүжилтийг даатгалын компани хариуцдаг байж болно. Санхүүжилтын хувьд даатгагч нараас бүрэн хамааралтай холбооны дэргэд эвлэрүүлэн зуучлалын төвийг байгуулах нь мөн л холбооны гишүүд буюу даатгагч нараас хамааралтай болох ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ. Иймд энэ ашиг сонирхлын зөрчлийг даван туулахын тулд эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааны (ажилчдын цалин хөлс, оффис байрны зардал зэрэг) санхүүжилтыг холбооноос хариуцаж болохч, харин эвлэрүүлэн зуучлагчийн зардлыг маргалдагч талууд хариуцдаг байхаар зохицуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл тухайн эвлэрүүлэн зуучлах төвд хамаарахгүй өөр бусад хараат бус эвлэрүүлэн зуучлагчийг талууд сонгодог байхаар зохицуулалт хийх нь зүйтэй.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Эвлэрүүлэн зуучлалын төвийг ямар ч хэлбэрээр байгуулж болох одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалах,
- Хувь эвлэрүүлэн зуучлагч бус эвлэрүүлэн зуучлалын төвөөр дамжуулж эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагддаг болох,
- Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвүүд магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах,
- Мэргэжлийн холбоодын дэргэд үүсгэн байгуулагдах эвлэрүүлэн зуучлалын төвүүдийн үйл ажиллагааны дүрэмд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээний талаар тусгаж өгөхийг шаардах,

5.3. Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих арга механизмын талаар

Судалгаанаас үзэхэд нэгдүгээрт эвлэрүүлэн зуучлалын сайн дурын загвар буюу талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэхээр харилцан зөвшөөрөх хэлбэр, хоёрдугаарт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхийг урамшуулах болон хариуцлагажуулах хэлбэр (хэрэв талууд эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлсэн бол улсын тэмдэгтийн хураамжийг нь буцаан олгох, хүндэтгэн үзэх шалтгаангүй эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоогүй талд улсын тэмдэгтийн хураамжийг хариуцуулах зэрэг), гуравдугаарт эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эхний уулзалтыг заавал хийх, дөрөвдүгээрт тодорхой төрлийн маргаанууд дээр эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгож хуульчлах зэрэг эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг өдөөх хөшүүргүүд байна. Үүнээс манай улсын хувьд гэрлэлт цуцлахтай холбоотой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгон хуульчилж өгчээ. Үүнээс үзвэл эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэх бусад арга замуудыг хуульд тусгаж өгөх, урьдчилан шийдвэрлэх журам тогтоох маргааны төрлийг өргөжүүлэх шаардлагатай байна.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Шүүгч аль ч шатанд, талууд зөвшөөрсөн бол эвлэрүүлэн зуучлалд маргааныг шилжүүлэх одоогийн зохицуулалтыг хадгалах,
- Талууд гэрээндээ маргаан гарсан тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсон бол урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалах,
- Шүүхэд хэрэг маргаан үүссэний дараа талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвхитэй оролцож эвлэрсэн бол улсын тэмдэгтийн хураамжийг нь буцаан олгох, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоогүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уулзалтанд ирээгүй талд хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох,
- Тодорхой (жижиг үнийн дүн бүхий маргаан, арилжааны маргаан, хэрэглэгчийн гэрээний маргаан зэрэг) төрлийн маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эхний уулзалтыг заавал хийсэн байхыг шаардах,
- Тодорхой төрлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалын урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байхыг шаардах,
- Эвлэрүүлэн зуучлалаар маргааны шийдвэрлүүлэх гэрээний загвар нөхцлүүдийг томоохон аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгох (тухайлбал, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүдэд үүрэг хүлээлгэх) зэрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өдөөх, хэрэглэх механизмуудыг санал болгож байна.

5.4. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах арга замын талаар

Манай улсад хувийн буюу шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хөгжөөгүй, зогсонги байдалд орсон үндсэн шалтгаан нь шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгаажуулдаггүй байсантай холбоотой байна.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Хувийн буюу шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвөөр дамжуулж байгуулсан эвлэрлийн гэрээг шүүг баталгаажуулдаг болох, ингэхдээ шүүхэд ажлын ачаалал нэмэгдүүлэхгүйн тулд хэрэв эвлэрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн, үүргээ зөрчиж эхэлсэнээр шүүхэд хүсэлт гаргаж, эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах байдлаар зохицуулах;
- Шүүхээс бусад байдлаар буюу арбитрын хэрэг үүссэний дараа талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрлийн гэрээ байгуулж болох байдлаар (arb-med-arb) буюу арбитраар мөн эвлэрлийн гэрээгээ баталгаажуулж болох зохицуулалтыг оруулж өгөх;
- Талууд эвлэрлийн гэрээгээ нотариатаар гэрчлүүлж, гэрээгээр хүлээн үүргээ үл маргах журмаар биелүүлэх нөхцөлийг харилцан тохиролцож гэрчлүүлэх, улмаар эвлэрлийн гэрээний үүргээ зөрчсөн бол нотариатын мэдэгдэх хуудас бичүүлж шүүхээр баталгаажуулах боломжийг нэмэгдүүлэх, энэ талаар шүүх болон нотариат нэгдсэн ойлголтод хүрэх.

5.5. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлагын талаар

Харьцуулсан судалгаанаас үзэхэд эвлэрүүлэн зуучлагч нь заавал эрх зүйч байх, хуульч байх шаардлагагүй байна. Энэ нь талууд өөрсдөө маргаанаа харилцан ярилцаж шийдвэрлэдэгтэй холбоотой байх бөгөөд олон талын мэргэжлийн хүмүүс эвлэрүүлэн зуучлагчаар ажиллах боломжийг нэмэгдүүлэх зэрэг давуу талтай. Харин эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч, хуульч байх шаардлага тавих нь эвлэрлийн гэрээ хууль зөрчөөгүй байх, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөөгүй байх гэсэн шалгуурыг хангахад давуу тал болж болох юм. Гэхдээ шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгч баталгажуулах боломжтой байдлаар хуулийг

өөрчилж байгаа тул эвлэрүүлэн зуучлагч нь заавал эрх зүйч байх шаардлагагүй байж болохоор байна.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч мэргэжилгүй байж болохоор зохицуулах;
- Эвлэрүүлэн зуучлалын төвд нь эвлэрлийн гэрээг хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн эсэхэд хяналт тавих үүргийг хүлээлгэх, энэ талаар авах арга хэмжээний талаар дүрэмдээ тусгахыг шаардах.

5.6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх маргааны төрөл хүрээг өргөжүүлэх эсэх талаар

Судалгаанаас авч үзвэл манай улсын эвлэрүүлэн зуучлалын хуулиар хувийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлахад баримтлах зарчим, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах журмыг хуульчилж өгсөн байна. Хуулийн 3.2 дахь хэсэгт хуульд тусгайлан заасан тохиолдолд эрүүгийн хэрэг, захиргааны хэрэгт бусад эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болохоор нээлттэй орхисон байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар буюу хувийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах зорилготой бичигдсэн хуулиар нийтийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлахаар маргааны төрлийг нэмэгдүүлэх зохимжгүй байна. Учир нь хувийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлахад хэрэглэгдэх зарчим нь, нийтийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад баримтлах зарчмаас ялгаатай байна.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар хувийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах харилцааг зохицуулах, энэ хүрээгээр хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлах;
- Эрүүгийн хэрэг, захиргааны хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэх бол өөр хуулиар зохицуулах, аль эсвэл тухайн салбарын процессын хуульд өөрчлөлт оруулах замаар зохицуулж өгөх;
- Хувийн эрх зүйн салбар дотроо зарим төрлийн хэрэг маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа тогтоох байдлаар эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх маргааны хүрээг өргөжүүлж өгөх.

5.7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааны талаар

Одоогийн хуульд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэснээс хойш 60 хоногийн хугацаанд талууд эвлэрэн хэлэлцэх боломжтой бөгөөд энэхүү хугацаанд багтаж эвлэрлийн гэрээ байгуулаагүй тохиолдолд тус ажиллагаа дуусгавар болохоор заажээ. Тодруулбал эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн хугацаа 30 хоног байх ба үүнийг талуудын хүсэлтээр нэг удаа сунгаж болно. Уг хугацааг шүүхийн болон арбитрын хэрэг хянан шийдвэрлэх хугацаатай харьцуулахад харьцангуй бага байна. Угтаа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хугацааны хувьд богино, түргэн шуурхай, хямд зардалтай байх онцлогтой боловч талуудын эвлэрэх боломжит хугацааг олгож өгсөнөөр эвлэрэл амжилттай болох үр дагавартай байдаг.

Иймд, дараах саналыг гаргаж байна:

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн хугацаа нь хүсэлт гаргаснаас хойш 30 хоног байх ба уг хугацааг нэг удаа бус талуудын хүсэлтээр хэдэн ч удаа сунгаж болох байдлаар өөрчлөх, Учир нь талууд эвлэрэн хэлэлцэхэд тухайн маргааны агуулга, нөхцөл байдлаас хамааран ялгаатай хугацаа шаардагдах ба хуулиар эвлэрэх хугацааны дээд хэмжээг тогтоох нь эвлэрэл амжилттай болоход сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Хэрэв талуудын аль альных нь хүсэлтээр хугацааг сунгаж, тус

хугацаанд эвлэрэх боломжтой байгаа тохиолдолд хугацааг хэдэн ч удаа сунгаж болох байдлаар хязгаарлалт хийлгүйгээр нээлттэй үлдээх нь зүйтэй.

Харин шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хугацааны тухайд аль болох эвлэрэх боломжит хугацааг тогтоож өгөх шаардлагатай хэдий ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны дотор багтаан явуулах нь зүйтэй бөгөөд нь энэ нь шүүхийн бусад ажиллагаатай эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэгдэх юм.

5.8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийн талаар

Одоогийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд зааснаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж нь маргааны үнийн дүнгээс үл хамааран 30000 төгрөг байна. Хураамж нь тухайн эвлэрүүлэн зуучлагч талуудад эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлсэний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө байх бөгөөд энэ нь эдийн засгийн нөхцөл байдал, инфляци зэрэгтэй уялдаж байх учиртай. Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хэрэгжиж эхлэснээс хойш өдгөө 12 жилийн хугацаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийг тухай бүрт нь шинэчлэн тогтоогоогүй, одоог хүртэл 30000 төгрөгөөр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд нийцээгүй байх тул хураамжийн хэмжээг өөрчлөх, хэрхэн тогтоох аргачлалыг хуульд тусгах шаардлагатай гэж үзлээ. Тиймээс хураамжийн хувь хэмжээтэй холбоотойгоор дараах саналыг гаргаж байна.

- Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тухайд маргааны үнийн дүнгээс хамааран интервал тогтоох нь зүйтэй. Бүх төрлийн эвлэрүүлэн зуучлалын маргаанд нэг дүнгээр хураамжийг тогтоох бус улсын тэмдэгтийн хураамжийг ялгаатайгаар хураах байдлаар зохицуулах шаардлагатай. Үүний учир нь маргааны үнийн дүн болон маргааныг эцэслэхэд шаардлагдах үйлчилгээний хураамж хоорондоо дүйцэж, тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаж байх нь зүйн хэрэг юм.
- Шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийн хураамжийн хэмжээг хуулиар зохицуулах шаардлагагүй бөгөөд тухайн төвүүд өөрсдөө байгууллагын дүрэм журмаараа хураамжийн хэмжээгээ тогтоож зохицуулах нь зүйтэй. Учир нь төрөөс хураамжийн хэмжээг тогтоож өгсөнөөр хувийн эвлэрүүлэн зуучлалын салбар зах зээлийн журмаараа бие даан хөгжих боломжийг хязгаарлах эрсдэлтэй. Мөн тухайн эвлэрүүлэн зуучлах төвүүдэд мэргэшсэн, чадварлаг эвлэрүүлэн зуучлагч ажиллаж өөрсдийн үнэлэмжийг тогтооход хязгаарлалт хийх нь тус салбар дахь мэргэжлийн байдал дээшлэхгүй байх шалтгаан болно. Тиймээс хувийн эвлэрүүлэн зуучлал дахь хураамжийн хэмжээг хуулиар тогтоохгүйгээр өөрсдөд нь байгууллагын дүрмээрээ тогтоох эрхийг олгох нь зүйтэй.

5.9. Эвлэрлийн гэрээний талаар

Эвлэрлийн гэрээний тухайд гэрээг байгуулах хэлбэр, түүний агуулга, тусгах нөхцөл шаардлага зэргийг ерөнхийд нь одоо байгаа хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзэж байгаа бөгөөд энэхүү судалгааны үндсэнд хууль дахь эвлэрлийн гэрээний зохицуулалтад дараах ялимгүй өөрчлөлтийг хийх нь оновчтой гэж үзлээ.

Эвлэрлийн гэрээнд он, сар, өдөр, тухайн эвлэрүүлэн зуучлагчийн овог, нэр, маргалдагч талуудын овог, нэр, хаяг, эвлэрүүлэн зуучлал эхэлсэн он, сар, өдөр, маргааны агуулга, тохиролцсон зүйлсийн талаар зайлшгүй тусгах шаардлагатай байна. Харин гэрээнд маргааны талаарх талуудын байр суурийг заавал тусгах шаардлагагүй

гэж үзлээ. Үүний учир нь нэгэнт талууд эвлэрлийн гэрээний нөхцөл дээр тохиролцсон бол энэ талаарх өөрийн байр суурийг эвлэлийн гэрээнд бичгээр илэрхийлэх шаардлага байхгүй бөгөөд эвлэрлийн гэрээнд өөрийн байр суурь маргааны агуулгыг бичгээр илэрхийлэх шаардлага тавигдахыг мэдсэнээр нээлттэй ярилцахаас сэрэмжлэх, дараа нь өөрийн байр суурь нь өөрийнх нь эсрэг нотлох баримт болох эсэх эргэлзээ үүсгэж, улмаар эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болох эрсдэлтэй. Түүнчлэн эвлэрлийн гэрээнд шаардлагагүй олон төрлийн мэдээлэл шаардах нь эргээд нууц хадгалах үүргийн зөрчилд хүргэж болзошгүй юм. Тиймээс эвлэрлийн гэрээнд тусгах шаардлагатай зүйлийн талаарх хуулийн зохицуулалтаас гэрээнд талуудын байр суурийг тусгах шаардлагыг хасах нь зүйтэй байна.

Мөн гэрээ байгуулах хэлбэрийн шаардлагын тухайд эвлэрлийн гэрээг цахимаар байгуулах тухай зохицуулах шаардлагатай. Учир нь Иргэний хуульд заасны дагуу цахим хэлбэрээр байгуулсан хэлцэл нь бичгээр байгуулагдсан хэлцлийн нэгэн адил хүчин төгөлдөр байх ба гагцхүү цахим хэлбэрээр гэрээ байгуулахад шаардагдах хуульд заасан шаардлагыг хангасан байвал зохино. Иймд эвлэрлийн гэрээг байгуулах хэлбэрийн шаардлагыг тодорхойлохдоо гэрээг цахим хэлбэрээр байгуулж болох талаар нэмж тусгах нь зүйтэй.

---oOo—

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/;
2. Хууль тогтоомжийн тухай хууль /2015 он/;
3. Иргэний хууль;
4. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль
5. Гэр бүлийн тухай хууль
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
7. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"

ДОТООДЫН ЭХ СУРВАЛЖ

1. “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн тайлбар” УБ 2012 он.
2. М.Батчимэг “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, түүний орчин үеийн чиг хандлага”, УБ 2018 он.
3. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тойм”, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2020 он.
4. JICA, Шүүхийн ерөнхий зөвлөл “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”, УБ 2020 он.
5. М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он.
6. У.Санчир-Уяа “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлалд тулгамдаж буй асуудал”, УБ 2017 он.
7. Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол улсын шүүхийн 2022 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”, УБ 2022 он.
8. Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүхийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан”, УБ 2018 он.
9. Шүүхийн ерөнхий зөвлөл “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2024 оны хагас жилийн мэдээ”, УБ 2024 он.
10. ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ийн санал, дүгнэлт” (Саналын дугаар: JUD-MNG/362/2019), 2020.05.11.

ГАДААДЫН ЭХ СУРВАЛЖ

11. Directive 2008/52/EC of the European Parliament and of the Council of 21 May 2008 on certain aspects of mediation in civil and commercial matters https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2008:136:0003:0008:En:PDF
12. Policy Department for Citizens’ Rights and Constitutional Affairs (2016) “The Implementation of Mediation Directive:Compilation of In-depth Analyses” https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2016/571395/IPOL_IDA%282016%29571395_EN.pdf
13. Comparative Study of the legal and institutional frameworks and best practices on commercial mediation with recommendations for the Republic of Serbia (2021) file:///C:/Users/Acer/Downloads/2A.%20ENG%20Study%20on%20Commercial%20Mediation%20in%20Serbia%20-%20Jun21%20(1).pdf

14. European Bank for Reconstruction and Development (EBRD) and the International Development Law Organization (IDLO) (2022) “This Brief Guide to Commercial Mediation and Its Practice”
Brief Guide Design in English_June 2022.pdf
15. Mark Batson Baril, Donald Dickey (n.d) “MED-ARB: The Best of Both Worlds or Just A Limited ADR Option?”
https://www2.mediate.com/pdf/V2%20MED-ARB%20The%20Best%20of%20Both%20Worlds%20or%20Just%20a%20Limited%20ADR%20Option.pdf
16. Robert Rinatovich Izmailov (2020) “Mediation in Russia: Law Enforcement Issues, Tendencies and Prospects”
17. Walter H. RECHBERGER (2015) “Mediation in Austria”
https://www.ritsumei.ac.jp/acd/cg/law/lex/rlr32/rechberger.pdf
18. UNCITRAL (2018) “United Nations Convention on International Settlement Agreements Resulting from Mediation”
https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/singapore_convention_eng.pdf
19. Italian Ministry of Justice (2011) “Italian legislation on Mediation”
mediation in Italy.pdf
20. 岡　英男（達）「 モンゴルの調停の特徴、土地紛争についての紛争解決と調停、日本の法整備支援によって導入された制度の定着に関する調査研究」（2024 年）
21. 山本和彦、山田　文、「ADR 仲裁法」（2008 年）
22. 民事調停手続きについて日本の裁判所のウェブサイト
https://www.courts.go.jp/saiban/syurui/syurui_minzi/minzi_04_02_10/index.html
23. UNCITRAL Model law on mediation
24. Mediation Act 2017 of The Statutes of The Republic of Singapore
https://storage.egazette.gov.sg/getFiles?ct=statutes&yr=2021&filename=21rs8264.pdf

ХАВСРАЛТ №1 МЭРГЭЖИЛТЭНТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

ЯРИЛЦЛАГА №1

1. Эвлэрлийн гэрээний баталгаажилтын талаар

Эвлэрлийн гэрээг баталгаажуулах 4 хувилбар байгаа. Орон болгон өөрийн онцлогоосоо шалтгаалан аль нэг хувилбараас сонгодог.

Тухайлбал Сингапурт батлагдсан конвенцод заасны дагуу эвлэрлийн гэрээг мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар баталсан бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил гүйцэтгэдэг. Олон улсын конвецод нэгдсэн. Сүүлд уг конвенцод турк, япон улсууд нэгдэн орсон байгаа.

Сүүлийн үеийн чиг хандлага нь маргаж буй талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэчихсэн тохиолдолд үүнийг заавал дахин баталгаажуулах шаардлагагүй. Бизнес эрхлэгчид өөрсдийн засаглалаараа хооронд үүссэн маргааныг шийдвэрлэсэн байхад шүүх заавал үүнийг баталгаажуулж оролцох шаардлагагүй буюу тэр эрхэнд нь хөндлөнгөө оролцох шаардлагагүй гэж үзэж байгаа.

Бусад улс орнуудын туршлагаас үзвэл баталгаажуулахаас илүү бүртгэдэг тогтолцоог хэрэгжүүлж байгаа. Шүүх эвлэрлийн гэрээг баталгаажуулдаг тогтолцоог манай хөрсөнд буулгах нь хэцүү. Учир нь шүүгчдэд өөр тусдаа газарт батлагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулахгүй, зөвхөн өөрсдийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан гэрээ байгуулсан бол батлана гэх хандлага бий. Өөрөөр хэлбэл хувь шүүгчийн амбицаас шалтгаалан хэрэгжих эсэх нь эргэлзээтэй.

Манай тохиолдолд арбитраар баталгаажуулсан нь илүү тохиромжтой. Эвлэрүүлэн зуучлалын болон арбитрын дүрмээр шийдэх боломжтой. Энэ нь хуулийг өөрчлөх шаардлагагүй байдгаараа хамгийн амар хялбар арга зам болдог.

Процедур нь арбитрын хэрэг үүсгээд талууд эвлэрлийн гэрээгээ байгуулсан гэдгээ мэдэгдээд үүнийг нь баталгаажуулах байдлаар практикт хэрэгжиж байгаа. Нэг үгээр хэлбэл хэлбэрийн төдий үе шатаар явж байгаа гэсэн үг.

Гэвч эцсийн дүндээ арбитрын ямар ч шийдвэр байсан шүүх дээр очиж баталгааждаг. Тиймээс арбитр, эвлэрүүлэн зуучлал 2-ын шийдвэр шууд шийдвэр гүйцэтгэл рүү очдог нээлттэй байдлаар зохицуулах нь зүйтэй байна.

Олон улсын туршлагаас үзэхэд шүүх эвлэрлийн гэрээг бүртгэдэг байгууллага байх нь зүйтэй. Сингапурын туршлагаас үзэхэд бүртгэдэг тогтолцоо нь хамгийн давуу талтайд тооцогдсон.

НҮБ-ийн конвенцийн дагуу эвлэрүүлэн зуучлагч өөрөө тухайн гэрээг хянах шалгах, 3дагч этгээдийн эрх хөндөгдсөн эсэхийг шалгах эрхтэй байх бөгөөд ямарваа нэг асуудалтай гэрээ байгуулагдсан тохиолдолд тухайн гэрээ хүчин төгөлдөр бус байх тухай заасан. Ингэснээр шүүгчийн гуравдагч этгээдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлсэн айдас буурах магадлалтай.

2. Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг дэмжих эрх зүйн механизмууд

Тодорхой төрлийн хэрэг маргаануудад нөхцөлт харьяалал тогтоож үүнийгээ хуульд тусгах байдлаар оруулах нь зүйтэй.

Гол нь иргэд, ААН, бизнес эрхлэгч нар эвлэрүүлэн зуучлалын ач холбогдлын тухай сайтар ойлгосон байх шаардлагатай. Эргээд нөгөө талаасаа эвлэрэл амжилттай болоход эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар, хүчин чармайлт шаардлагатай.

Хөгжингүй орнуудад эвлэрүүлэн зуучлалын бүхэл бүтэн бүтэц системтэй тогтолцоо бий болчихсон байгаа. Тиймээс хувийн эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэхийн тулд иргэдийнхээ нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сурталчилгаа хийж, анхаарч үзэх шаардлагатай байгаа.

3. Хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдийг магадлан итгэмжлэх шаардлагатай эсэх

Олон улсын жишгээ дагаад магадлан итгэмжилсэн нь зүйтэй.

Магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулахад шүүгчид итгэл төрнө. Өөрөөр хэлбэл хувийн эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжилчихвэл шүүгч арай итгэлтэйгээр эвлэрлийн гэрээг баталгаажуулна.

Хууль зүйн яам нь магадлан итгэмлжлэх нь зүйтэй.

Харин нөгөө талаасаа хүнд суртал үүсэх эрсдэлтэй. Энийг А Б хувилбар байж болох юм гэдэг байдлаар судалгаандаа оруулчихвал зүгээр.

4. Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага

Орон орноосоо шалтгаалаад өөр өөр байдаг. Монголын хөрсөнд эрх зүйч мэргэжилтэй хүн байх нь зүйтэй. Манай улсад 3000 гаруй бэлтгэгдсэн эвлэрүүлэлн зуучлагч нар байгаа. Энэ нь хангалттай хүний нөөц байгаа гэсэн үг юм. Тиймээс заавал өөр мэргэжил рүү хөрвүүлэх шаардлага байхгүй байх. Эвлэрүүлэн зуучлагчийн сургалтанд суусан хүн арай өөрөөр хандах магадлалтай.

Олон улсад бол заавал эвлэрүүлэн зуучлагчийн тусгай зөвшөөрөл авдаг. Одоо монголд тийм зүйл байхгүй. Шалгалт аваад ямар ч мэргэжлийн хүн байсан мэдлэгээ сургалтаараа нөхөөд авах боломжтой. Тиймээс тусдаа лиценз олгодог байдлаар эвлэрүүлэн зуучлагчдын чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай.

5. Эвлэрүүлэн зуучлалын төв ямар хуулийн этгээд байх нь зүйтэй вэ?

ТББ байсан нь зүйтэй. Компани гэсэн хэлбэртэй ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байх нь төдийлөн тохиромжтой биш.

Жишээ дурьдвал Арбитрч нар “арбитрч” гэх статусаараа ажиллах дургүй болчихсон. Учир нь тэнхимд харьяалагддаг учраас тэнхим орлогийн 50 хувийг авдаг. Түүнээс нь 50 хувийг арбитр буюу төв нь авдаг. Үлдсэн 50 буюу 25 хувийг л тухайн маргааныг шийдсэн дөрвөн арбитрч нь хувааж авдаг. Энэ нь өмгөөлөгчийн хөлснөөс ч бага дүнтэй байдаг. Тиймээс эдийн засгийн талаасаа арбитрч, эвлэрүүлэн зуучлагч нарт баталгаа бий болгох ёстой. Эвлэрүүлэн зуучлалын хөгжүүлэхийн тулд эдийн засгийн талаас нь зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүү нь тусдаа болсоноор цаашдаа хөгжих, өргөжих боломж бүрдэнэ.

6. Хил дамнасан эвлэрүүлэн зуучлал

2019 оны НҮБ-ийн конвенцод хил дамнасан эвлэрүүлэн зуучлалын талаарх бүх зохицуулалт байгаа. Тэр конвенцод л нэгдэх нь жижиг улс орнуудын хувьд ашигтай байдаг. Нэгдсэнийхээ дараа хуульч нар нь тэр талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Мэдлэггүй байвал нөгөө талаасаа эрсдэлтэй.

Энэ талаар заавал хууль дээрээ нарийвчлан зохицуулах шаардлагагүй.

(Олон улсын эвлэрүүлэн зуучлалын тухай хууль гарах гэж байгаа тухай Япон багшаасаа сонссон гэнэ ээ.)

Хэрэв конвенцдоо нэгдэн орчихвол дараа тусдаа бүлэг болгоод оруулж болно. Гэхдээ дотоодын зохицуулалт болон гадаадын зохицуулалт буюу конвенцод буй заалт хоорондоо эсрэгцэх магадлалтай. Учир нь конвенцод буй заалт нь эвлэрлийн гэрээ шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх байдлаар зохицуулагдсан.

7. Маргааны хүрээг өргөсгөх талаар

Хуульч нарын оролцоо энд зайлшгүй шаардлагатай. Маргаан гарвал юуны өмнө эвлэрэхийг хичээгээд, дараад нь эвлэрүүлэн зуучлах төвд хандана гэж гэрээнд тусгахыг үйлчлүүлэгчид зөвлөдөг, эвлэрүүлэн зуучлалыг сурталчилдаг болох шаардлагатай.

Захиргааны хувьд татварын эвлэрүүлэн зуучлал гэж байгаа. Энэ тал дээр Монголд дэлхийд буй чиг хандлагаа барисан нь зүйтэй. Харин хангалттай түвшинд хөгжсөнийхөө дараа хөрвөх боломжтой.

Захиргааны байгууллага буулт хийх: Татварын маргаан таслан комиссын үйл ажиллагаа нь үр дүнгүй.

8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа

Талууд хүссэн тохиолдолд сунгах байдлаар уян хатан, нээлттэй зохицуулалт хийсэн нь зүйтэй. Мөн улс орнуудын хуулийн хугацааг харж үзээд төстэй байдлаар тогтоосон нь зүйтэй.

9. УТХ

Хувийн секторт байгуулагдсан эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлалын хураамжийг хуулиар тогтоох шаардлагагүй. Тусдаа байгууллага байх учраас уг хураамжийг тухайн төв өөрөө удирдлагаараа шийдэж тогтоох нь зүйтэй.

Шүүх дэх улсын тэмдэгтийн хураамжийн дүн одоогийн нөхцөлд харьцангуй бага байгаа. Гэхдээ өндрөөр тогтоох нь эрсдэлтэй.

БМЭЗ-ийн үнэ тогтоох журам: тогтсон үнийн дүн бүхий хураамжтай байгаагүй. Тухайлбал …. төрлийн маргаан нь ….. хувийн тэмдэгтийн хураамж төлнө гэх байдлаар интервалын аргаар зохицуулж байсан.

10. Эвлэрлийн гэрээнд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлс.

Шүүхэд бүртгүүлэхийн тулд эвлэрлийн гэрээнд зүйл тусгах шаардлагатай зүйлс гэж бий. Сингапурын жишээнээс харж болно.

11. Өөр бусад

Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах ёс зүйн дүрэм байх шаардлагатай төдийгүй тухайн ёс зүйн дүрэм нь хариуцлагын тогтолцоо бүхий нарийн зохицуулалттай байх шаардлагатй. Одоо байгаа ёс зүйн дүрэм нь хэлбэрийн төдий хэрэгжилт хангалтгүй байдаг.

Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл ёс зүйн дүрмийг батлах бол цаашлаад зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох эрх бүхий этгээд хэн байх вэ гэдэг талаас нь бас сайн бодох шаардлагатай.

ЯРИЛЦЛАГА №2

Эвлэрлийн гэрээг шүүх болон арбитрын шийдвэрээр баталгаажуулах нь хамгийн боломжит хувилбар мөн. Шүүхээр баталгаажуулах тохиолдолд шүүхийн ажлын ачааллын асуудлын талаар авч үзэх шаардлагатай. Харин арбитраар баталгаажуулах тохиодолд төдийлөн ноцтой асуудал үүсэхгүй гэж бодож байна.

Эвлэрүүлэн зуучлалын ерөнхий зөвлөлийг Улсын дээд шүүхийн дэргэд байгуулах нь зүйтэй. Учир нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь шүүн таслах ажиллагааны нэг хэлбэр мөн учраас Улсын дээд шүүхийн дэргэд байгуулах нь зүйтэй.

Өндөр үнийн дүнтэй хэрэг дээр эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг. Маргаан нь даамжирсаар талууд бараг л эвлэрэх боломжгүй болчихсон байдаг. Тиймээс хязгаарлалтын зохицуулалт хийх нь зүйтэй.

Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд сэтгэл зүйч оролцох хэрэгцээ шаардлага ихээхэн үүсч байгаа. Талуудын сэтгэл зүйн байдлыг мэргэжлийн үүднээс харж, зөвлөж чадахуйц сэтгэл зүйч мэргэжилтэй эвлэрүүлэн зуучлагч байх, эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд сэтгэл зүйчийг оролцуулах шаардлагатай байна.

Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагчийг сонгоход насны хязгаарлалт тавих шаардлагатай байна. Учир нь практикт эвлэрүүлэн зуучлагч нь үйлчлүүлэгчээс нас залуу хүн байвал эвлэрүүлэн зуучлалд хандахгүй байх магадлал өсдөг.

Эвлэрүүлэн зуучлалын талаарх шүүгч нарын мэдлэгийг өсгөх шаардлагатай байна. Угтаа шүүгч нар талуудад эвлэрэх боломжтой тухай сануулж, энэ боломжийг олгож байх шаардлагатай байна.